МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

"БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ШИНЭЧЛЭЛ" ТӨСӨЛ

# ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН ГАРЫН АВЛАГА

## ТАВДУГААР ШАТ



2021

# ӨМНӨХ ҮГ

## *Эрхэм хүндэт бага ангийн багш, сурагч, эцэг эхчүүд ээ,*

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр (СТХ)-ийг 2021-2022 онд үргэлжлүүлэхээр шийдвэрлэснийг дуулгахад таатай байна.

Бага боловсролын чанарыг ахиулах зорилгоор Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг 2015 оноос 4 үе шаттайгаар хэрэгжүүлсний үр дүнд бага ангийн багш нар хамтарч төслийн санал бичих, төслөө хамтран хэрэгжүүлэх, төслийн санхүүжилтээ сургууль бие даан зарцуулах зэрэг олон шинэ үйл ажиллагаанд суралцаж, улмаар бага ангийн сурагчдын хөгжилд бодитой хувь нэмэр оруууллаа. Ялангуяа бага боловсролын эх хэл, математик, байгалийн ухааны хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэх зорилтын төлөө сургуулиуд тодорхой үр дүнд хүрч, нийтдээ бүх ЕБС-ийн 70 хувь нь хоёр удаа төсөл хэрэгжүүлээд байна.

БШУЯ-наас бага боловсролын тулгамдсан асуудал, хэрэгцээ, шаардлагыг харгалзан СТХ-ийн 5 дугаар шатыг хэрэгжүүлэхдээ КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй хичээлийн хоцрогдлыг нөхөх зорилгоор мэдээллийн технологи, е-боловсролын ололтыг бага ангийн сургалтад туршин хэрэгжүүлэх томоохон зорилтыг дэвшүүлж байна.

Сургуулиуд төслийн саналаа хамт олноороо хэлэлцэн, сургууль бүр өөр өөрийн өнгө аястай, бүтээлч, шинэлэг саналууд төлөвлөн ирүүлнэ хэмээн найдаж байна. Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй учраас бага ангийн багш бүрийн оролцоо, сэтгэл, санаачилга чухал бөгөөд төслийн шинэлэг санаа оноо гаргахын тулд бусад орны тэргүүн туршлагаас судлахын сацуу мэдээллийн технологийн орчин, нөхцөл сургууль бүрд харилцан адилгүй байгааг харгалзан оновчтой төслийн санал ирүүлэхийг уриалж байна.

СТХ-ийг амжилттай хэрэгжүүлэхэд бүх шатны удирдлага, сургууль, багш нар хичээл зүтгэл гаргаж амжилттай хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Бага боловсрол тэгш, хүртээмжтэй, чанартай байж, дэлхийн түвшинд гайхагдах амжилтын төлөө хамтдаа зүтгэцгээе!

Эрдэм номын буян дэлгэрэх болтугай.

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

# АГУУЛГА


01 **Товчилсон үг**

02 **Тодорхойлолт**

03 **Төслийн товч танилцуулга**

04 **I. ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ**

05 **II. ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО**

05 **2.1** Бага боловсролын тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатны зорилго юу вэ, ямар онцлогтой вэ?

06 **2.2** 5 дугаар шатыг хэрэгжүүлснээр сургууль болоод Боловсролын газар, хэлтсүүдийн түвшинд ямар үр дүнд хүрэх ёстой вэ?

07 **2.3** 5 дугаар шатанд ямар төрлийн тэтгэлэг олгох вэ?

08 **III. ТӨСӨЛ БИЧИХИЙН ӨМНӨХ ШАТ**

08 **3.1** Сургуулиуд 5 дугаар шатанд оролцохын тулд юунаас эхлэх вэ?

10 **3.2** Дээр дурдсан тэтгэлгийн төрөл тус бүрд нийцэхүйц мэдээллийн технологийн шийдлийг ашиглаж болох үйл ажиллагааны жишээ юу байж болох вэ?

13 **IV. СТХ-ИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

13 **4.1** Төслийн санал гэж юу вэ?

13 **4.2** Ямар төслийн санал дэмжигдэх магадлал өндөр вэ?

13 **4.3** Ямар төслийг санхүүжүүлэх боломжгүй вэ?

14 **4.4** Тэтгэлгийн зохион байгуулалтыг хаанаас удирдах вэ?

14 **4.5** Зохион байгуулалтад оролцогч талуудын үүрэг юу байх вэ?

16 **4.6** Сургуульд олгох тэтгэлгийн хэмжээ хэд вэ?

17 **4.7** Мэргэжилтэнд олгох тэтгэлгийн хэмжээ хэд вэ?

18 **4.8** Зөвшөөрөгдөх зардлууд гэж юу вэ?

18 **4.9** Тэтгэлгийн санхүүжилтийн гэрээ гэж юу вэ?

18 **4.10** Тэтгэлгийг хаанаас санхүүжүүлж байгаа вэ?

19 **4.11** Тэтгэлгийн санхүүжилтээ хэрхэн хүлээж авах вэ?

20 **4.12** Санхүүжилтийн зарцуулалтыг хэрхэн тайлагнах вэ?
20 **4.13** Төслийн санхүүгийн бичиг баримтыг хэдий хүртэл хадгалах ёстой вэ?
20 **4.14** Төслийг ямар хугацаанд хэрэгжүүлэх вэ?
21 **4.15** Төслийн хэрэгжилтийн цагалбар ямар байх вэ?
23 **V. ТӨСЛИЙН САНАЛАА БЭЛТГЭХ ҮЕ ШАТ**
23 **5.1** Төслийн саналаа бичиж эхлэхэд юуг мэдвэл зохих вэ?
24 **5.2** Төслийн саналын загварыг хаанаас авах вэ?
25 **5.3** Төслийн саналаа хэрхэн илгээх вэ?
27 **VI. ТӨСЛИЙН САНАЛЫГ ХЯНАХ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ**
27 **6.1** Зөвлөмж өгөх үе шат
28 **6.2** Төслийг ямар шалгуураар үнэлэх вэ?
29 **6.3** Төслийн үнэлгээ дууссаны дараагаар юу хийх ёстой вэ?
29 **6.4** Гэрээ байгуулах үе шатыг хэрхэн зохион байгуулах вэ?
30 **VII. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ БА МОНИТОРИНГ**
30 **7.1** Худалдан авах ажиллагааны журмаас
32 **7.2** Худалдан авах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах вэ?
34 **VIII. ТАЙЛАГНАЛТ, АУДИТ БА МОНИТОРИНГ**
34 **8.1** Төслийн тайланг хэрхэн ирүүлэх вэ?
34 **8.2** Төслийн санхүүгийн аудитыг хэн хийх вэ?
35 **8.3** Төслийн хэрэгжилтийн мониторингийг хэрхэн зохион байгуулах вэ?
36 **8.4** БЧШТ, СТХ-ийн хэрэгжилтийн талаарх санал, өргөдөл, гомдол хэрхэн гаргах вэ?

# ХАВСРАЛТ

i **Хавсралт А.** Сургуулийн мэдээллийн технологийн бэлэн байдлын өөрийн үнэлгээний хуудас

ii **Хавсралт Б.** Тэтгэлгээр санхүүжүүлэхэд зөвшөөрөгдөх зардлууд

iii **Хавсралт В.** Төслийн санал боловсруулах загвар

v **Хавсралт Г.** Төслийн тайлангийн загвар

vii **Хавсралт Д.** Бараа, зөвлөх үйлчилгээ худалдан авахад үнийн санал авах, зөвлөх үйлчилгээ шалгаруулахад ашиглах загвар

viii **Хавсралт Е.** Гэрээний загвар: БШУЯ, БСУГ, сургууль хооронд байгуулах

xv **Хавсралт Ё.** Төслийн саналын жишээ

xvii **Хавсралт Ж.** Олон улсын зарим туршлагаас

xx **Хавсралт З.** Эх сурвалжийн каталог

xx Нэг. Бага боловсролд зориулсан мэдээллийн технологийн онлайн бүтээгдэхүүний жагсаалт

xxxi Хоёр. Англи хэл дээрх математик, байгалийн ухааны мэдлэг олгох бүтээгдэхүүний жагсаалт

xxxix Гурав. Багшийн мэдээллийн технологийн чадвар, цахим, интерактив хичээл боловсруулахад ашиглах боломжтой бүтээгдэхүүний жагсаалт

01

# ТОВЧИЛСОН ҮГ

| | |
|---|---|
| *БШУЯ* | ***Боловсрол, шинжлэх ухааны яам*** |
| *БЧШТ* | ***Боловсролын чанарын шинэчлэл төсөл*** |
| *ДБ* | ***Дэлхийн банк*** |
| *ЗГ* | ***Засгийн газар*** |
| *БСУГ* | ***Боловсрол, соёл, урлагийн газар*** |
| *СТСГ* | ***Сургуулийн тэтгэлгийн санхүүжилтийн гэрээ*** |
| *АХ* | ***Ажлын хэсэг*** |
| *СТ* | ***Сургуулийн тэтгэлэг*** |
| *СЗ* | ***Сургуулийн зөвлөл*** |
| *ТС* | ***Төслийн санал*** |
| *ОУХА* | ***Олон улсын хөгжлийн ассоциаци*** |
| *ХМБ* | ***Хяналт мониторингийн баг*** |

# ТОДОРХОЙЛОЛТ

| | |
|---|---|
| *Аймаг* | **Засаг захиргааны нэгж, 21 аймаг** |
| *Аймаг, нийслэлийн БСУГ, хэлтэс* | **Боловсрол, соёл, урлагийн газар** |
| *Аймаг нийслэлийн БСУГ, хэлтсийн бага боловсрол хариуцсан мэргэжилтэн* | **Уг мэргэжилтэн СТХ-ийн хэрэгжилтийг зангидан хариуцна.** |
| *Сургуулийн тэтгэлэг* | **Сургууль бие даан хэрэгжүүлэх төсөл** |
| *Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр* | **БШУЯ-наас хэрэгжүүлэх БЧШТ-ийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсэг** |
| *Төслийн санал* | **Төслийн санал нь тухайн сургууль бодит нөхцөл байдалдаа тулгуурлаж боловсруулсан төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө. ТС нь сурагчдын амжилтыг ахиулах, суралцах арга барилыг төгөлдөржүүлэх, ялангуяа унших бичих, өөрийгөө илэрхийлэх чадвар ба математик чадварт ахиц дэвшил гаргахад чиглэсэн үйл ажиллагааг багтаах ёстой.** |
| *СТХ-ийн оролцогч тал* | **·Ерөнхий боловсролын сургуулиуд<br>·Нийслэлийн боловсролын газар, дүүргүүдийн боловсролын хэлтэс, Аймгийн БСУГ ба тухайн газар, хэлтсийн Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн** |
| *Интерактив сургалтын арга* | **Суралцагсдын оролцоог дэмжсэн идэвхтэй сургалтын хэлбэрүүд** |
| *Блэндэд арга* | **Танхимын уламжлалт сургалтын аргуудыг мэдээллийн технологи ба онлайн сургалтын шийдэлтэй хослуулан хэрэглэх арга зүй** |

# ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**ТӨСЛИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО:**
Бага боловсролын эх хэл, байгалийн ухаан ба математикийн сургалтын чанар, үр дүнг сайжруулж, сургуулийн түвшинд төлөвлөлтийг бэхжүүлэх замаар бага боловсролын чанарыг сайжруулах, Ковид-19 цар тахлын үед "Хүүхдийн мөнгөн тэтгэмж"-д дэмжлэг үзүүлэхэд оршино.

**ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧИД:**
Бүх ЕБС-ийн бага ангийн сурагч, эцэг эх, бага ангийн багш, сургуулийн удирдлага

**СУРГУУЛИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ:**
Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн СТХ-т зориулах 1.7 сая ам.доллар

Төсөл 5 бүрэлдэхүүн хэсэгтэй.

1. Сургалтын үр өгөөжийг сайжруулах

2. Бага ангийн багшийн мэргэжлийн ур чадварыг багш бэлтгэх шатанд болон ажлын байранд нь ахиулах

3. Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх

4. Төслийн удирдлага, хяналт-шинжилгээ ба үнэлгээ

5. Коронавирусын халдварын цар тахлын үед иргэдийн амьжиргааг хамгаалах, “Хүүхдийн мөнгөн тэтгэмж” хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх

# I. ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

*"Бага боловсролын чанарыг сайжруулах, сургалтыг дэмжих бүтээлч үйл ажиллагааны агуулгыг баяжуулах зорилготой"*

Дэлхийн банкны санхүүжилтээр БШУЯ-наас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төсөл (БЧШТ)-ийн хүрээнд Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр (СТХ) 2015 оноос хойш 4 үе шаттайгаар хэрэгжиж байна. Төрийн өмчийн 656 ЕБС нь нийтдээ 1447 төсөл хэрэгжүүлээд байна. Энэхүү гарын авлагын агуулга, зарчим нь Дэлхийн банк ба Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулсан БЧШТ-ийн Санхүүжилтийн хэлэлцээрт үндэслэсэн болно. Гарын авлагыг 2021-2022 онд СТХ-ийн 5 дугаар шатанд мөрдлөг болгоно.

# II. ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

## 2.1 БАГА БОЛОВСРОЛЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН 5 ДУГААР ШАТНЫ ЗОРИЛГО ЮУ ВЭ, ЯМАР ОНЦЛОГТОЙ ВЭ?

Тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатны зорилго нь “КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан бага ангийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, алслагдсан бүс, нутгийн сурагчдад суралцах тэгш боломж олгох, мэдээллийн технологийн шийдлийг ашиглах замаар сургууль бүр төслийн бүтээлч, оновчтой санал боловсруулан турших, сурагчдын амжилтыг ахиулах”-ад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

5 дугаар шат дараах онцлогтой. Үүнд:

I. Тэтгэлэгт хөтөлбөрийн хөрөнгийг КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан хичээлийн хоцрогдлыг нөхөх үйл ажиллагаанд зарцуулна;
II. Сургууль төслийн оновчтой шийдлийг дэвшүүлэхдээ бодит хэрэгцээ, нөхцөл байдалдаа нийцтэйгээр сургууль бүр сайн, чанартай санал бэлтгэх, мэдээллийн технологийн шийдэл ашиглахад голчлон анхаарна;
III. Тухайн сургуульд ногдох санхүүжилтийн хэмжээ нь бага ангийн сурагчийн тооноос хамааралтай байна.

## 2.2 5 ДУГААР ШАТЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР СУРГУУЛЬ БОЛООД БОЛОВСРОЛЫН ГАЗАР, ХЭЛТСҮҮДИЙН ТҮВШИНД ЯМАР ҮР ДҮНД ХҮРЭХ ЁСТОЙ ВЭ?

**I.** Бага ангийн багш мэдээллийн технологийн дэвшлийг сургалтдаа ашиглах, интерактив, блэндэд аргууд нэвтрүүлэх чиглэлээр чадавхаа дээшлүүлэх;

**II.** Хичээлийн хоцрогдлыг нөхөх зорилгоор сургууль, аймаг, дүүрэг бүр өөрсдийн брэнд болохуйц сургалтын цахим хэрэглэгдэхүүн, аппликэйшн ашиглаж, турших боломжийг эрэлхийлэх;

**III.** Аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтсийн түвшинд мэдээллийн технологийн боловсролыг хөгжүүлэх хүний нөөцийн чадавхыг ахиулах;

**IV.** БШУЯ-ны портал (БМДИ)-д шаардлага, стандартад нийцсэн интерактив цахим агуулга болоод хичээлийн тоог нэмэгдүүлэх.

## 2.3 5 ДУГААР ШАТАНД ЯМАР ТӨРЛИЙН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ВЭ?

Доор дурдсан 2 төрөлд ангилж байна. Үүнд:

# СУРГУУЛЬ:



Сургууль “Мэдээллийн технологийн бэлэн байдлын өөрийн үнэлгээ” хийж, дараах хоёр төрлийн (1.А ба 1.Б) аль нэгийг сонгоно. Ийнхүү ангилж буйн ач холбогдол нь сургууль нөхцөл, боломждоо тулгуурлаж, төслийн саналаа бичихэд чиглүүлэх зорилготой. Үүнд:

1. А. Мэдээллийн технологийг ашиглах нөхцөл, боломж хязгаарлагдмал сургууль;
1. Б. Мэдээллийн технологийг ашиглах нөхцөл, боломж дундаас дээд түвшний сургууль.

# МЭРГЭЖИЛТЭН:



Аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтсийн бага боловсрол хариуцсан мэргэжилтэнд зориулсан тэтгэлэг

# III. ТӨСӨЛ БИЧИХИЙН ӨМНӨХ ШАТ

## 3.1 СУРГУУЛИУД 5 ДУГААР ШАТАНД ОРОЛЦОХЫН ТУЛД ЮУНААС ЭХЛЭХ ВЭ?

### 1.УДИРДАМЖТАЙ ТАНИЛЦАХ

•Юуны өмнө, YouTube сувгаар байршуулах төслийн санал хэрхэн бэлтгэх тухай видеог бага ангийн бүх багш үзэж судална;
•Энэхүү гарын авлагын е-хувилбартай бие даан танилцана (БШУЯ-ны цахим хуудаст).

### 2.СУРГАЛТАД ХАМРАГДАХ

•Аймаг, нийслэлийн БСУГ, хэлтсээс зохион байгуулах онлайн сургалтад сургуулийн захирал, бага ангийн сургалтын менежер, бүх бага ангийн багш, сургуулийн нягтлан бодогч хамрагдана.

## 3.ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

•Сургууль бүр мэдээллийн технологийн бэлэн байдлын түвшиндээ үнэлгээ хийн, 1.А эсвэл 1.Б ангиллын аль нэгийг сонгоно. Хавсралт А-д өгсөн шалгуурыг ашиглана.

## 4.САНАЛ БОЛОВСРУУЛАХ, ИЛГЭЭХ

•Бага ангийн багш нар хамтран төслийн бүтээлч санаагаа хэлэлцэн дэвшүүлж (төслийн жишиг санааг 3.2-т доор харуулав), төслөө бичиж, БМТТ-өөр дамжуулан БШУЯ-д илгээнэ.

## 5.САНАЛЫГ САЙЖРУУЛАХ, ИЛГЭЭХ

•Ажлын хэсгээс сайжруулах шаардлагатай гэсэн зөвлөмж өгсөн тохиолдолд зөвлөмжийн дагуу төслийн саналаа засч, сайжруулаад дахин илгээнэ. .

## 3.2 ДЭЭР ДУРДСАН ТЭТГЭЛГИЙН ТӨРӨЛ ТУС БҮРД НИЙЦЭХҮЙЦ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛИЙГ АШИГЛАЖ БОЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИШЭЭ ЮУ БАЙЖ БОЛОХ ВЭ?

**1.А төрөл: "Мэдээллийн технологийг ашиглах нөхцөл, боломж хязгаарлагдмал сургууль"-д санаа өгөх зорилгоор дараах жишээг санал болгож байна. Үүнд:**

**i.** Интерактив цахим хичээл бэлтгэх, ашиглах чиглэлээр бага ангийн бүх багшид сургалт явуулж, сургалтын үр дүнгээ турших;
**ii.** Сурлагын хоцрогдолтой хүүхдэд зориулан яамны https://econtent.edu.mn/content/library.html сайт зэрэг нээлттэй эх ашиглан офлайн цахим давтлагын агуулга боловсруулах, турших;
**iii.** Интернетгүй орчинд хоцрогдолтой сурагч бие даан хичээллэхэд зориулан аудио сургалтын хэрэглэгдэхүүн, агуулга бэлтгэх, турших, хэвлэмэл материалтай хослуулах. Жишээ нь, MP3 тоглуулагч, гар утасны аппликэйшн ашиглах;
**iv.** Танхимын сургалтад мэдээллийн технологи ашиглах замаар блэндэд хэлбэрт оруулах (жишээ нь, гар утасны мэссэжийг ашиглан багшийн чиглүүлгээр хүүхдүүд бие биенээсээ суралцах платформ ашиглах, гар утас ба мэссэжээр квиз ажиллуулах гэх мэт);
**v.** Малчин эцэг эхэд зориулсан мэдээллийг аудио хэлбэрээр хэвлэмэл материалтай хослуулан бэлтгэж турших. Жишээ нь, эцэг эхэд зориулан сонин гаргах, захидал илгээх, анги бүрээр аудио хичээл, сэтгүүл бэлтгэж илгээх.

**1.Б төрөл: "Мэдээллийн технологийг ашиглах нөхцөл, боломж дундаас дээд түвшний сургууль"-д санаа өгөх зорилгоор дараах жишээг санал болгож байна. Үүнд:**

**i.** Интерактив/тоглоомын арга зүйд суурилсан монгол хэлний цахим хичээл бэлтгэх чиглэлээр багш нарт сургалт явуулж, сан бүрдүүлэх, сурагч бие даан компьютер дээр турших. Жишээ нь, хичээлийн хоцрогдолтой хүүхдэд зориулсан тоглоомын аргаар хүүхэд бие даан суралцах орчин бүрдүүлж турших, гэртээ бие даан хичээллэх цахим агуулга бэлтгэх;

**ii.** Бага ангийн заах аргын нэгдэл хамтран математик ба байгалийн ухааны хичээлийн туршилтууд, сургалтын тоглоом зэргийг гадаадын нээлттэй эх, аппликэйшн ашиглан нэвтрүүлэх;

**iii.** Судлагдахуун бүрээр мэдлэг шалгах даалгаврын сан зохиох, явцын үнэлгээний аппликэйшн, програм ашиглах сургалтыг багш нарт явуулах, нэвтрүүлж турших;

**iv.** Багш нар хамтарч, интерактив хичээлийн брэнд болохуйц сан бүрдүүлэх, БМДИ-гийн платформд шилжүүлэн нийтийн хүртээл болгох;

**v.** Хүүхдийн зан үйл, эрүүл мэндийн боловсрол, харилцаа, нийгэм-сэтгэл зүйн чадварыг хөгжүүлэх болон сэтгэл хөдлөлөө удирдах зэрэг сэдвээс сонгон цахим агуулга бэлтгэх, эцэг эхэд хүргэх, орон нутгийн мэдээллийн хэрэгсэлтэй хамтарч ажиллах, цацах (тоглоомын хэлбэрээр, анимэйшн, шог зураг, орон нутгийн түүхийн богино хэмжээний цуврал гэх мэт)

**vi.** Мэдээллийн технологи ашиглах чадвар илүү сайтай багш нар ментороор ажиллах замаар багш нар хамтран шинэлэг дижитал сургалтын арга барил эзэмших, турших

**Төрөл 2: БСУГ, хэлтсийн мэргэжилтэнд санаа өгөх зорилгоор дараах жишээг санал болгож байна. Үүнд:**

**i.** Одоогоор бэлэн болсон цахим хичээлийг анги, судлагдахүүн бүрээр ангилах, эрэмбэлэх, хадгалах нэгдсэн сан үүсгэх технологийн шийдлийг судалж нэвтрүүлэх;
**ii.** Интерактив сургалтын аппликэйшн боловсруулдаг мэдээллийн технологийн байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтрах замаар нэг судлагдахууныг сонгон брэнд цахим хэрэглэгдэхүүн боловсруулан турших, аймаг, дүүргийн түвшинд бүх бага ангийн багш нарт эзэмшүүлэх;
**iii.** Аймаг, дүүргийн түвшинд бүх багш нарт явцын үнэлгээний шинэ аппликэйшнийг нэвтрүүлэх;
**iv.** БСУГ, хэлтсийн бага боловсрол хариуцсан мэргэжилтнүүдийн мэдээллийн технологийн боловсролын чадавхыг дээшлүүлэх сургалтад хамрагдах, сургалтын үр дүнг турших;
**v.** Орон нутгийн мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах.
**vi.** Багш, сургуулийн дунд мэдлэгээ хуваалцах, харилцан туршлага солилцох.

# IV. СТХ-ИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## 4.1 ТӨСЛИЙН САНАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Төслийн санал (ТС) нь СТХ-ийн 5 дугаар шатны ерөнхий зорилтын хүрээнд сургууль өөрөө төлөвлөн боловсруулсан, зорилго ба үйл ажиллагаа нь нягт уялдаатай нарийвчилсан төлөвлөгөө юм. ТС-ын загварыг гарын авлагын Хавсралт Б-ээс үзнэ үү.

## 4.2 ЯМАР ТӨСЛИЙН САНАЛ ДЭМЖИГДЭХ МАГАДЛАЛ ӨНДӨР ВЭ?

Бага ангийн сурагчдын, ялангуяа 1 ба 2 дугаар ангийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөхийн тулд мэдээллийн технологийг үр өгөөжтэй, шинэлэг хэлбэрээр ашиглах оновчтой шийдэл бүхий төсөл илүүтэй дэмжигдэх болно. Мөн зөвхөн бараа, хэрэглэгдэхүүний худалдан авалт хийх зорилго агуулсан төслийг дэмжих боломжгүй бөгөөд харин худалдан авсан хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөө сурагчдад хүрэх бүтээлч үйл ажиллагаа болгож чадсан эсэхийг чухалчилна.

## 4.3 ЯМАР ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОМЖГҮЙ ВЭ?

Бага ангийн багш, сурагчдад үзүүлэх үр нөлөө багатай зүйлс (жишээ нь, зургийн аппарат, өсгөгч, чанга яригч, прожектор гэх мэт цахилгаан бараа, бичгийн хэрэглэл, шохой, цаас гэх мэт) эсвэл дэлгүүрээс худалдан авалт хийх зорилготой бараа бүтээгдэхүүний жагсаалт, тавилгын жагсаалт, барилгын засвар болон түүнтэй холбогдох ажлыг энэхүү тэтгэлгээр санхүүжүүлэх боломжгүй юм.

## 4.4 ТЭТГЭЛГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ХААНААС УДИРДАХ ВЭ?

Үндэсний хэмжээнд БШУЯ хөтөлбөрийг удирдан зохион байгуулна. Аймаг, нийслэлийн түвшинд аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтсээс бага боловсрол хариуцсан мэргэжилтэн хэрэгжилтэд хяналт тавьж, сургуульд зөвлөн тусална. Сургуулийн түвшинд сургуулийн захирал, бага ангийн сургалтын менежерийн зүгээс дэмжлэг үзүүлж бага ангийн багш нартайгаа хамтран ажиллана.

Мөн аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтсээс мониторингийн баг ажиллах ба багийн томилолтын зардлыг БЧШТ-өөс хариуцна.

## 4.5 ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ ЮУ БАЙХ ВЭ?

**А. Аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтэс ба тухайн газар, хэлтсийн бага боловсрол хариуцсан мэргэжилтний үүрэг:**

**i.** Аймаг, дүүргийнхээ бага ангийн бүх багшид цахим сургалт зохион байгуулж, зөвлөн туслах;

**ii.** Санамсаргүй түүврээр сонгосон сургууль дээр очиж, төслийн хэрэгжилтэд хяналт мониторинг хийх;

**iii.** Газар, хэлтсийн удирдлагын зүгээс Тэтгэлэг хэрэгжүүлэх санхүүжилтийн гэрээ байгуулах ажлыг сайтар зохион байгуулах;

**iv.** Сургуулиас төслийн тайланг хүлээн авч, нэгтгэн, сканердсан (PDF) хувийг БШУЯ-ны дэргэдэх төслийн албанд eqrpmon@gmail.com хаягаар илгээх;

**v.** Сайн төслийн жишээг баримтжуулан түгээн дэлгэрүүлэх (жишээ нь сургуулийн тэтгэлгийн нэгдсэн facebook хуудас).

**Б. Аймаг, нийслэлийн Төрийн сангийн үүрэг:**
**i.** Сангийн яамнаас шилжүүлэх сургуулийн тэтгэлгийн санхүүжилтийг хүлээн авч, сургууль бүрийн нэмэлт санхүүжилтийн дансанд цаг хугацаанд нь шилжүүлнэ;
**ii.** Төсвийн хуваарилалтын ердийн механизмыг ашиглан бүртгэж, тайлагнана;
**iii.** СТХ-ийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах хариуцлагыг хүлээнэ.

**В. Сургуулийн захирал, нягтлан бодогчийн үүрэг:**
**i.** Сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд тэтгэлгийн санхүүжилтийг хүлээн авч, бага ангийн сургалтын менежер болоод багш нартайгаа хамтран, төслийн санал дээрх төсвийг үндэслэн санхүүжилтийг энэхүү гарын авлагын дагуу зарцуулна;
**ii.** Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага хүлээх ба санхүүгийн шаардагдах баримт бичгийн иж бүрдлийг хангана;
**iii.** Аудит болон мониторингийн багт шаардлагатай тохиолдолд тайлагнана.

## 4.6 СУРГУУЛЬД ОЛГОХ ТЭТГЭЛГИЙН ХЭМЖЭЭ ХЭД ВЭ?

Сургуульд олгох тэтгэлгийн санхүүжилт сурагчийн тооноос хамааран ялгаатай байх ба

- 300 хүртэлх сурагчтай бол 4,300,000;
- 301-500 хүртэлх сурагчтай бол 8,000,000;
- 501 ба түүнээс дээш тооны сурагчтай бол 10,600,000 төгрөг байна.



## 4.7 МЭРГЭЖИЛТЭНД ОЛГОХ ТЭТГЭЛГИЙН ХЭМЖЭЭ ХЭД ВЭ?

БСУГ, хэлтсийн мэргэжилтэнд олгох тэтгэлгийн санхүүжилт тухайн нэгжийн харъяа сургуулийн тооноос хамааран ялгаатай байх ба

- 5 хүртэлх сургуультай бол 5,700,000;
- 10-20 хүртэлх сургуультай бол 9,800,000;
- 21-30 хүртэлх сургуультай бол 11,300,000;
- 31 ба түүнээс дээш тооны сургуультай бол 12,800,000 төгрөг байна.



### 4.8 ЗӨВШӨӨРӨГДӨХ ЗАРДЛУУД ГЭЖ ЮУ ВЭ?

Төслийн хүрээнд санхүүжүүлж болох “Зөвшөөрөгдөх зардлууд”-ын жагсаалтыг энэхүү гарын авлагын Хавсралт Б-д өгсөн. Үүнд:

- Сургалтын материал ба хэрэглэгдэхүүний зардал;
- Сургалт;
- Зөвлөх үйлчилгээний зардал;
- Үйл ажиллагааны зардал.

Мөн БЧШТ-ийг Дэлхийн банкнаас санхүүжүүлж байгаа учраас БШУЯ ба сургуулиуд заавал мөрдвөл зохих худалдан авах үйл ажиллагаа ба санхүүгийн журмыг дагах үүрэг хүлээдэг бөгөөд үүнд (i) СТ-ийн хүрээнд бараа, үйлчилгээ худалдан авах; (ii) СТ-ийг хэрэгжүүлэх санхүүгийн тайлагналтын журмууд багтана.

### 4.9 ТЭТГЭЛГИЙН САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Тэтгэлгийн санхүүжилтийн гэрээ (ТСГ) нь БШУЯ-наас ЕБС, БСУГ, хэлтэст төслийн санхүүжилт олгох тухай хоёр талын гэрээ юм. Гэрээг БШУЯ ба аймаг, нийслэлийн Боловсролын газар, БСУГ-ын хооронд байгуулсны дараа төсөл хэрэгжүүлэгч (сургуулийн захиргаа ба БСУГ-ын мэргэжилтэн гэх мэт) ба аймаг, нийслэлийн Боловсролын газар, БСУГ-ын хооронд тус тус байгуулна. Гэрээний загварыг Хавсралт Е-д харуулсан болно.

### 4.10 ТЭТГЭЛГИЙГ ХААНААС САНХҮҮЖҮҮЛЖ БАЙГАА ВЭ?

Монгол Улсын Засгийн газар болон Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциациас “Боловсролын чанарын шинэчлэл” төслийг хэрэгжүүлэхэд олгож буй зээлийн төслөөс санхүүжүүлэх юм.

## 4.11 ТЭТГЭЛГИЙН САНХҮҮЖИЛТЭЭ ХЭРХЭН ХҮЛЭЭЖ АВАХ ВЭ?

Санхүүжилтийг төсвийн хуваарилалтын ердийн механизмыг ашиглан, тэтгэлэгт төсөл хэрэгжүүлэх тухай гэрээ ба Сайдын тушаалыг үндэслэн, Сангийн яамны зөвшөөрлийн дагуу төслийн данснаас аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтэс ба ЕБС-ийн нэмэлт санхүүжилтийн дансанд нэг удаа 100 хувь шилжүүлнэ. Санхүүжилтийн урсгалыг харуулбал:



## 4.12 САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХЭРХЭН ТАЙЛАГНАХ ВЭ?

Санхүүжилтийг зарцуулахдаа улсын төсвийг захиран зарцуулах ба тайлагнах журам, ердийн механизмыг ашиглана. Тэтгэлэгт төсөл хэрэгжүүлэх тухай гэрээ ба Сайдын тушаалыг үндэслэн, Сангийн яамны зөвшөөрлийн дагуу төслийн данснаас аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтэс ба ЕБС-ийн нэмэлт санхүүжилтийн дансанд нэг удаа 100 хувь шилжүүлнэ. Санхүүжилтийн урсгалыг харуулбал:

## 4.13 ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХЭДИЙ ХҮРТЭЛ ХАДГАЛАХ ЁСТОЙ ВЭ?

Төсөл хэрэгжиж, дуусгавар болсноос хоёр жилийн дотор баримт, бичгүүдийг хадгална.

## 4.14 ТӨСЛИЙГ ЯМАР ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?

2021-2022 оны хичээлийн жил буюу 2021 оны 9 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж, 2022 оны 5 дугаар сарын 20 гэхэд дуусгавар болохоор төлөвлөнө.

## 4.15 ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЦАГАЛБАР ЯМАР БАЙХ ВЭ?

СТХ-т оролцогч талууд төслийг үр өгөөжтэй зохион байгуулахад дараах хуанлийг мөрдөнө.

| | |
|---|---|
| **1.1 Бага боловсрол хариуцсан мэргэжилтний сургалт** | IV.7-8 |
| **1.2 Бага боловсрол хариуцсан мэргэжилтнүүд YouTube суваг дахь хичээлийг ашиглан сургалт зохион байгуулах** | IV.10-19 |
| **2 СТХ 5 дугаар шат эхэлснийг зарлах** | IV.19 |
| **3 Сургууль, БСУГ төслийн саналаа бэлтгэх** | IV.19-V.3 |
| **4 Ажлын хэсэг төслийн саналд зөвлөмж өгөх** | V.3-9 |
| **5 Засаж сайжруулсан төслийн санал хүлээж авах** | V.10-14 |

| | |
|---|---|
| 6 БШУЯ, БСУГ, сургуулиудтай гэрээ байгуулах | V.30 |
| 7 Гэрээний дагуу санхүүжилт олгох | VIII.15 |
| 8 СТХ 5 дугаар шатыг хэрэгжүүлж эхлэх | IX.1 |
| 9 5 дугаар шатны хэрэгжилтэд БСУГ мониторинг, зөвлөн туслах | III.30 (2022) |
| 10 БСУГ, сургуулиуд төслийн эцсийн тайланг ирүүлэх | V.20 |

# V. ТӨСЛИЙН САНАЛАА БЭЛТГЭХ ҮЕ ШАТ

## 5.1 ТӨСЛИЙН САНАЛАА БИЧИЖ ЭХЛЭХЭД ЮУГ МЭДВЭЛ ЗОХИХ ВЭ?

Багш нар сургалтад хамрагдсаны дараагаар төслийн саналаа хамтран бичиж эхэлнэ. Төслийн санал бэлтгэхэд түгээмэл мөрддөг доорх зөвлөмжийг хүргэж байна. Аливаа төсөл зорилго, үйл ажиллагаа, үр дүн гэсэн хоорондоо нягт уялдаатай, логик холбоотой хэсгүүдээс бүрдэнэ.

**1. АСУУДАЛ:**

- Тухайн сургуулийн тулгамдсан асуудлыг тодорхойлохдоо сурагчдын хэрэгцээ, сургуулийн онцлог, сул ба давуу талыг харгалзана.

**2. ТӨСЛИЙН САНАА буюу ЗОРИЛГО:**

- Дээр тодорхойлсон асуудлыг шийдэх хамгийн оновчтой шийдэл нь төслийн санаа болж өгнө. Төслийн санаа нь таны зорьж буй ЗОРИЛГО юм. Гагцхүү төслийн зорилго нь тодорхой, бүтээлч, шинэлэг байх ёстой.

**3. ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

- Төслийн зорилгодоо хүрэх хамгийн оновчтой арга замууд нь үйл ажиллагаа болж задарна. Үйл ажиллагаанууд хоорондоо уялдаа холбоотой байх ёстой.

**4. ҮР ДҮН:**

- Төслийн зорилго биелэгдсэний дараагаар зорилтот бүлэгт гарах өөрчлөлт, ахиц нь төслийн ҮР ДҮН. Үр дүн бодитой, тоон үзүүлэлтээр хэмжигдэхүйц байна.

**ДҮГНЭЛТ:** Төслийн зорилго, үйл ажиллагаа, үр дүн гурав нь хоорондоо нягт уялдаатай байхын тулд зайлшгүй шийдэх ёстой асуудлаа сонгоно. Асуудлын шийдэл нь төслийн **САНАА буюу ЗОРИЛГО** болно. Зорилгоос **ҮЙЛ АЖИЛЛАГАА** урган гарна. Үйл ажиллагаанаас **ҮР ДҮН** бий болно. Таны бичсэн төсөл энэ логик дараалалтай нийцэж байвал сайн төслийн санал болжээ хэмээн үзэж болно.




## 5.2 ТӨСЛИЙН САНАЛЫН ЗАГВАРЫГ ХААНААС АВАХ ВЭ?

Төслийн саналын загварыг энэхүү гарын авлагын Хавсралт В-д өгсөн ба дараах хэсгүүдтэй. Үүнд:

- Сургууль, багш, мэргэжилтний ерөнхий мэдээлэл;
- Төслийн зорилго, хүрэх үр дүн;
- Үйл ажиллагааны төлөвлөгөө;
- Зардлуудын задаргаа;
- Төслийн тогтвортой байдлын стратеги.

Төслийн саналын загвар нь мөн БМТТ-ийн цахим портал дээр байршсан болно.




## 5.3 ТӨСЛИЙН САНАЛАА ХЭРХЭН ИЛГЭЭХ ВЭ?

**БМТТ-өөр дамжуулан сургууль төслийн саналаа цахимаар илгээх заавар:**

**Алхам 1.** Сургуулийн сургалтын менежер өөрийн эрхээрээ БМТТ-ийн esis.edu.mn сайтад нэвтэрч, “Сургуулийн мэдээллийн технологийн бэлэн байдлын өөрийн үнэлгээ”-ний хуудсыг бөглөж илгээх (Хавсралт А-д загвар бий);




**Алхам 2.** Багш нарын хамтран боловсруулсан төслийн саналыг загварын дагуу бөглөн сургуулийн захирлын гарын үсэг, сургуулийн тамгаар баталгаажуулан илгээх;






**Алхам 3.** БШУЯ-ны Ажлын хэсэг нь сургуулиас ирүүлсэн төслийн саналыг үнэлж, шаардлагатай тохиолдолд зөвлөмж бэлтгэж, БМТТ-өөр дамжуулан сургуульд мэдэгдэх ба сургуулиуд засаж сайжруулсан саналаа ажлын 5 хоногийн дотор дахин илгээнэ.




**БСУГ, хэлтсийн мэргэжилтний хувьд:**

**Алхам 1.** Төслийн саналыг БМТТ-өөр дамжуулан (Хавсралт В-д төслийн саналын загвар бий) цахимаар илгээх;

**Алхам 2.** БШУЯ-ны Ажлын хэсэг нь ирүүлсэн төслийн саналыг үнэлж, шаардлагатай тохиолдолд зөвлөмж бэлтгэж, БМТТ-өөр дамжуулан мэргэжилтэнд мэдэгдэх;

**Алхам 3.** Ажлын хэсгийн зөвлөмжийг саналдаа тусган засаж сайжруулсан эцсийн хувилбарыг БМТТ-ийн цахим хуудсаар дамжуулан илгээх.

# VI. ТӨСЛИЙН САНАЛЫГ ХЯНАХ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

## 6.1 ЗӨВЛӨМЖ ӨГӨХ ҮЕ ШАТ

Энэхүү үе шатны хамгийн чухал хэсэг нь сургууль бүр сайн төсөл ирүүлэхэд БШУЯ анхаарч байгаа бөгөөд үүний тулд дараах алхмыг хэрэгжүүлнэ.

- БШУЯ-ны Ажлын хэсэг сургуулийн төслийн саналыг оноогоор үнэлнэ.
- Сайн үнэлэгдсэн төслийг тэнцүүлж, доогуур оноотой үнэлэгдсэн төслийн саналыг сайжруулах зөвлөмжийг Ажлын хэсэг бэлтгэнэ.
- Сургууль зөвлөмжийн дагуу төслийн саналаа ажлын 5 хоногийн дотор засварлан сайжруулж, БМТТ-өөр илгээнэ.



## 6.2 ТӨСЛИЙГ ЯМАР ШАЛГУУРААР ҮНЭЛЭХ ВЭ?

Ажлын хэсгээс төслийн саналыг үнэлэхдээ дараах шалгуурыг баримтлах ба шалгуур тус бүрээр оноо өгнө.

- **ШАЛГУУР 1:** Төсөл нь хичээлийн хоцрогдлыг нөхөх шинэлэг санаачилгыг дэвшүүлсэн эсэх, мэдээллийн технологийн оновчтой шийдлийг гаргасан эсэх
- **ШАЛГУУР 2:** Төслийн үр дүн нь бодитой, хэмжигдэхүйц эсэх
- **ШАЛГУУР 3:** Төлөвлөсөн үйл ажиллагаа нь төслийн зорилготой нягт уялдаатай бөгөөд зохион байгуулалтын хувьд хэрэгжихэд хялбар, багш, хүүхдэд үр өгөөжтэй эсэх
- **ШАЛГУУР 4:** Төслөөс нийлүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн (үйл ажиллагаа) нь тогтмол хэрэглээ болж чадах эсэх
- **ШАЛГУУР 5:** Төсвөө оновчтой төлөвлөсөн эсэх

### АЖЛЫН ХЭСЭГ ОНОО ӨГӨХ АРГАЧЛАЛ

**2 оноо**
**Шалгуурыг бүрэн хангасан**

**1 оноо**
**Шалгуурыг тодорхой хэмжээнд хангасан**

**0 оноо**
**Шалгуур хангаагүй**

### ОНООГ НЭГТГЭН ДҮГНЭХ

**8 ба дээш**
**Тэнцсэн санал**

**7 ба доош**
**Сайжруулах санал**

## 6.3 ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ ДУУССАНЫ ДАРААГААР ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Ажлын хэсгийн зөвлөмжийг тэтгэлэгт хөтөлбөрийн оролцогч талууд сайтар тусгасан эсэхийг нягталсны дараагаар санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн төслийн жагсаалтыг БШУ-ны Сайдын тушаалаар батламжлан, улмаар тэтгэлгийн санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурах дараачийн шатны ажлыг зохион байгуулна.

## 6.4 ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ҮЕ ШАТЫГ ХЭРХЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ВЭ?

БШУЯ, Аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтэс, төслийн баг хамтран зохион байгуулна.

# VII. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ БА МОНИТОРИНГ

Төслийн санхүүжилтийг оролцогч талууд хүлээн авч, улмаар төслийн саналын дагуу хэрэгжилтийг зохион байгуулна. Юуны өмнө, шаардлагатай худалдан авалтыг сургуулийн захиргаа зохион байгуулна. Ингэхдээ худалдан авах ажиллагааны журмыг баримтална. Зарим журмаас доор оруулав.

## 7.1 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААС

Бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах” тухай хууль болон Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны журмыг баримтална.



Бараа ажил үйлчилгээг дараах хоёр аргаар худалдан авах боломжтой. Үүнд:

### 1. ШУУД ХУДАЛДАН АВАЛТ (ЖИЖИГ БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ)

Үнийн дүн нь 1 сая төгрөг хүртэлх бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авч болно. Жишээлбэл: нэг сая хүртэлх үнийн дүн бүхий сургалтын хэрэглэгдэхүүн, сургалттай холбоотой бичиг хэргийн зүйлс. Сургалт явуулсан тохиолдолд сургагч багшид олгох ажлын хөлс нь нэг сая төгрөгөөс хэтрэхгүй бол ажлын хөлсийг шууд гэрээ байгуулан олгож болно.

### 2. ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР ХУДАЛДАН АВАХ

Үнийн дүн нь 1 сая төгрөг ба түүнээс дээш тохиолдолд харьцуулалтын аргыг ашиглана. Харьцуулалтын арга гэдэг нь ижил түвшний чанар бүхийижил төрлийн бараа, ажил үйлчилгээ үзүүлдэг компани болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн 3 ба түүнээс дээш үнийн саналд үндэслэн бараа ажил үйлчилгээ худалдан авахыг хэлнэ. Үнийн санал авах маягтыг Хавсралт Е-д заасан.

## 7.2 ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРХЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ВЭ?

### А. ҮНИЙН САНАЛ АВАХ:

Үнэлгээний хороо байгуулж, барааны техникийн тодорхойлолт, зөвлөн үйлчилгээний ажлын даалгавар ба үнийн саналын урилга бэлтгэн,түүнийгээ 3 ба түүнээс дээш компани, аж ахуйн нэгжид илгээн цахим хэлбэрээр үнийн саналыг авч болно. Хэрвээ компани, аж ахуйн нэгжээс үнийн санал ирээгүй тохиолдолд хугацааг сунгах арга хэмжээ авна. Мөн урилгыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж болно. Нээлттэй зарлаад үнийн санал ирээгүй эсвэл зөвхөн нэг компани, аж ахуйн нэгжээс үнийн санал ирүүлсэн тохиолдолд тухайн компани, аж ахуйн нэгжтэйгэрээ байгуулж болно.

Жич: Хэрвээ үнийн саналын урилга бэлтгэхэд хүндрэлтэй бол Сангийн сайдын 2013 оны 5-р сарын 31-ний өдрийн 125 тоот тушаалын нэгдүгээр хавсралт ба ажил үйлчилгээ авах бол Сангийн сайдын 2013 оны 5-р сарын 31-ний өдрийн 125 тоот тушаалын хоёрдугаар хавсралтад заасан жишиг баримт бичгийг ашиглаж үнийн саналын баримт бичгийг ашиглаж болно.

### Б. ҮНИЙН САНАЛЫГ ҮНЭЛЭХ:

Үнэлгээний хороо нь үнийн саналыг хянан, үнэлгээний дүгнэлт гаргаж, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиралд өгнө. Үнэлгээг хийхдээ техникийн шаардлагыг бүрэн хангасан бөгөөд хамгийн бага үнийн санал ирүүлсэн компани болон зөвлөх үйлчилгээний хувьд хувь зөвлөхийг сонгон шалгаруулна.

**В. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ:**
Үнэлгээний хорооны дүгнэлтэд үндэслэн захиалагч буюу сургуулийн захирлын тушаалаар шалгарсан компани болон зөвлөх үйлчилгээний хувьд хувь зөвлөхтэй гэрээ байгуулна. Үнийн саналын баримт бичигт заасан гэрээний маягтыг ашиглаж болно.

**Г. ГЭРЭЭГ ДУУСГАВАР БОЛГОХ:**
Гэрээт ажил болон барааг хүлээн авсны дараа гэрээг дуусгавар болгосон акт үйлдэж бараа, ажил, үйлчилгээг хүлээн авна.

# VIII. ТАЙЛАГНАЛТ, АУДИТ БА МОНИТОРИНГ

## 8.1 ТӨСЛИЙН ТАЙЛАНГ ХЭРХЭН ИРҮҮЛЭХ ВЭ?

Тэтгэлгийн төслөө дуусгавар болмогц аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтэс нь сургуулиас тайланг хүлээн авч нэгтгэн, сургууль бүрээр нэгдсэн нэг PDF файл болгон цахимаар БШУЯ-ны дэргэдэх төслийн албанд ирүүлнэ.

## 8.2 ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН АУДИТЫГ ХЭН ХИЙХ ВЭ?

БЧШТ-ийн хэрэгжилтэд бие даасан аудитын компани аудит хийх ба тэтгэлгийн үйл ажиллагааны хэрэгжилтийг энэхүү аудитаар хамарна.



## 8.3 ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГИЙГ ХЭРХЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ВЭ?

ЕБС-ийн түвшинд захирал, бага ангийн сургалтын менежер нь багш нартайгаа сард нэг удаа тогтмол уулзаж, төслийн хэрэгжилтээ хэлэлцэнэ. Төслийн хэрэгжилтэд мониторинг хийх, зөвлөн туслах зорилгоор дараах байгууллагууд хамтран ажиллана.

- БШУЯ ба БЧШТ;
- Аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтсийн Мониторингийн баг;
- Эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан олон нийт;
- БЧШТ-ийн үйл ажиллагаанд хийх хөндлөнгийн аудит;
- Санамсаргүй сонгосон сургуулиуд дээр хөндлөнгийн үнэлээч ажиллах;
- Дэлхийн банкны төслийн багаас зургаан сар тутамд БШУЯ-тай хамтран зарим сургууль дээр очиж, төслийн хэрэгжилттэй танилцана.

Аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтсийн мониторингийн багаас зарим ЕБС-д очиж, төслийн хэрэгжилттэй биечлэн танилцана. Мониторингийн явцад худалдан авах үйл ажиллагаанд шалгалт хийн, холбогдох хууль, журмыг зөрчсөн тухайлбал зах зээлийн үнээс өндөр худалдан авалт хийсэн, хуучин бараа авсан зэрэг техникийн шаардлагад нийцэхгүй худалдан авалт хийсэн тохиолдолд **Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээний 2.1.4-р зүйлд заасны дагуу буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх арга хэмжээг, Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг санхүүжүүлэх гэрээний 2.1.4-р зүйлд заасны дагуу санхүүжилтийг буцаан татах хүртэл арга хэмжээ авна.**

## 8.4 БЧШТ, СТХ-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ САНАЛ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

**Санал, өргөдөл, гомдол гаргах**

Төслийн гэрээт гүйцэтгэгчид, эрх бүхий байгууллагууд болон бусад оролцогч талууд аливаа эрх нь хөндөгдсөн гэж үзвэл санал, өргөдөл, гомдол гаргаж болно. Тухайлбал, төсөл, СТХ хэрэгжих хугацаанд зохисгүй хөндлөнгийн оролцоо илэрсэн, төслийн аливаа зарчим, журам зөрчигдсөн, эсвэл өөрийн эрх зөрчигдсөн гэж үзсэн ямар ч асуудал байж болно. Өргөдөл, гомдол гаргагчийн хувийн нууцыг байнга хадгалах бөгөөд зөвхөн гомдол гаргагчийн бичгээр олгосон зөвшөөрлийг үндэслэн ил тод зарлаж болно.

**Өргөдөл, гомдол хүлээн авах**

Төсөл хэрэгжих хугацааны аль ч үед өргөдөл, гомдол гаргаж болно. Өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бичгээр, амаар болон цахим хэрэгслээр гаргаж болно. Гарын авлагын эцэст оруулсан БЧШТ-ийн албан ёсны хаяг, цахим хаягаар өргөдөл, гомдлыг хүлээн авна.

**Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх**

Өргөдөл, гомдлыг дараах үе шаттайгаар шийдвэрлэнэ.

**Алхам 1.** Өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх;

**Алхам 2.** Өргөдөл, гомдлыг баримтжуулах, анхны хариуг өгөх;

**Алхам 3.** Боломжтой шийдлийг судлан өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэх;

**Алхам 4.** Өргөдөл, гомдол гаргагчид өгөх хариу:

а/ Өргөдөл, гомдол гаргагч хариуг зөвшөөрвөл тохиролцсон шийдлийг хэрэгжүүлэх;

б/ Өргөдөл, гомдол гаргагч хариуг зөвшөөрөхгүй бол дараагийн шатны байгууллагад хүргүүлэх.

# ХАВСРАЛТ А.

## СУРГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Дараах асуултад **ТИЙМ** эсвэл **ҮГҮЙ** гэж хариулна.

Харин **ТИЙМ** гэсэн хариулт давамгайлж байгаа бол (80% ба түүнээс дээш), танай сургууль 1. Б. Мэдээллийн технологийг ашиглах нөхцөл, боломж дундаас дээш түвшний сургууль гэсэн төрөлд хамаарна.

Бусад тохиолдолд, танай сургууль 1. А. Мэдээллийн технологийг ашиглах нөхцөл, боломж хязгаарлагдмал сургууль гэсэн төрөлд хамаарна.

| 1. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ДЭД БҮТЭЦ, ХОЛБОЛТ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ |
|---|
| 1.1 Багш нар дундаа ашигладаг компьютертэй юу? |
| 1.2 Бүх багш зөөврийн компьютертэй юу? |
| 1.3 Бүх ангид зурагт суурилуулсан уу? |
| 1.4 Бүх багш ухаалаг гар утас ашигладаг уу? |
| 1.5 Танай сургуулийн интернетийн хурд 10 MB уу? |
| 1.6 Танай сургуулийн интернетийн хурд 100 MB уу? |
| 1.7 Танай сургууль дээр Wi-Fi, 3G, 4G ашиглах боломжтой юу? |
| 1.8 Эцэг эх, асран хамгаалагчийн 70-аас дээш хувь нь цахим орчинд холбогдсон гар утас ашигладаг уу? |
| 1.9 Сургуулийн дотуур байранд интернетийн холболттой эсэх, компьютер ашиглах боломжтой юу? |
| **2. ДИЖИТАЛ АГУУЛГА (БАГШЛАХУЙ БА СУРАЛЦАХУЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН)** |
| 2.1 Бага ангид зориулсан цахим сургалтын хэрэглэгдэхүүн, цахим хичээлийн сантай юу? |
| 2.2 Хичээл дээрээ интернет ашигладаг уу? |
| 2.3 Багш нар хамтарч цахим хичээл агуулга бэлтгэдэг үү? |
| 2.4 Үнэлгээний арга хэрэгслийг цахимаар ашигладаг уу? |
| **3. БАГШИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН МЭДЛЭГ, ЧАДВАР** |
| 3.1 Багш нар Windows үйлдлийн системийг сайн ашиглаж чаддаг уу? |
| 3.2 Багш нар хичээлээ бэлтгэхдээ бүгд интернет ашигладаг уу? |
| 3.3 Хичээл бэлтгэхдээ гадаадын сайтуудаас мэдээлэл ашигладаг уу? |
| 3.4 Интерактив хичээл бэлтгэж чадах уу? |
| 3.5 Онлайн сургалтад тогтмол хамрагддаг уу? |

# ХАВСРАЛТ Б.

## ТЭТГЭЛГЭЭР САНХҮҮЖҮҮЛЭХЭД ЗӨВШӨӨРӨГДӨХ ЗАРДЛУУД

Тэтгэлгийн санхүүжилтийг сургуулиуд зөвхөн зөвшөөрөгдөх зардалд зарцуулах ёстой. Сургалтын үйл ажиллагаанд үр нөлөө багатай зүйлс (жишээ нь, бичгийн хэрэглэл, шохой, цаас гэх мэт) эсвэл дэлгүүрээс худалдан авалт шууд хийх зорилготой бараа бүтээгдэхүүний жагсаалт, тавилгын жагсаалт, барилгын засвар болон түүнтэй холбогдох ажлыг энэхүү СТ-ээр санхүүжүүлэх боломжгүй юм. Дараах зардлууд зөвшөөрөгдөх зардалд хамаарна.

**НЭГ. Сургалтын материал ба хэрэглэгдэхүүн:** тухайн төслийн зорилттой нийцэхүйц сургалтын хэрэглэгдэхүүн (жишээ нь, цөөн тооны сургалтын төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, түүнтэй холбогдон гарах зардлууд зэрэг гэх мэт).

**ХОЁР. Зөвлөх үйлчилгээ:** бага боловсролын чанарыг ахиулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх **техник туслалцаа буюу мэргэжлийн багш урих гэх мэт:** түр хугацаагаар багш нарт дижитал боловсролын чиглэлээр сургалт хийх гадны сургагч багш ажиллуулах, бага боловсролд зориулсан онлайн бүтээгдэхүүн турших, гадаадын хэвлэлээс мэдээлэл авахад туслах мэргэжлийн хүн түр ажиллуулах гэх мэт.

**ГУРАВ. Сургалт:** Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай багшид зориулсан сургалтуудыг санхүүжүүлнэ. Харин удирдлагын сургалт орохгүй.

**ДӨРӨВ. Үйл ажиллагаа:** Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны жижиг зардлууд, жишээ нь, сурагчдын судалгаат аялалд шаардагдах багахан хэмжээний зардал болох унааны зардал гэх мэт

*ДАРААХ ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОНО*:

- Аливаа барилга байгууламж **барих, их засвар хийх;**
- **Нүх ухах, усан хангамжийн ажил;**
- Төслийн саналд тусгагдаагүй өөр бусад **бараа бүтээгдэхүүн;**
- Төслийн саналд тусгагдаагүй **зөвлөх үйлчилгээ, сургалт;**
- Сургуулийн багш нар, ажилчдын **цалин урамшуулал;**
- Багш, эцэг эхийн уулзалтад зориулсан **хоол, хүнс, ундаа;**
- “Сургалтад суусны төлбөр” ба урамшуулал;
- Бүх төрлийн **Татвар ба бусад төлбөр (шалгалтын төлбөр).**

*СУРГУУЛЬ ТЭТГЭЛГИЙГ ЭДГЭЭРТ ЗАРЦУУЛСАН БОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛНЭ.*

# ХАВСРАЛТ В.

## ТӨСЛИЙН САНАЛ БОЛОВСРУУЛАХ ЗАГВАР

Төслийн нэр: ....................................

**Хэсэг I.** СТХ-т оролцогчийн мэдээлэл

| |
|---|
| Аймаг/ хот: |
| Сум /дүүрэг: |
| ЕБС (Аймаг, нийслэлийн Боловсролын газар, хэлтэс)-ийн хаяг: |
| Захирлын (даргын) овог, нэр: |
| Бага ангийн сургалтын менежер, газар хэлтсийн бага боловсрол хариуцсан мэргэжилтний овог, нэр: |

**Хэсэг II.** Төслийн зорилго ба хүрэх үр дүн (тал хуудас)

| | |
|---|---|
| Зорилго (1 өгүүлбэр) | ***Бага ангийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөхийн тулд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах бүтээлч, оновчтой шийдлийг боловсруулан туршихад*** чиглэсэн байна. |
| Хүрэх үр дүн | Үр дүн нь хэмжигдэхүйц байна |
| Төслийн үр шим хүртэгчдийн тоо: | Багш ..... Сурагч ..... Эцэг эх ..... |

**Хэсэг III.** Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө (Доорх хүснэгтийн дагуу төсөл хэрэгжүүлэх хугацааны төлөвлөсөн ажлуудаа нэг хуудсанд багтаана)

| д/д | Үйл ажиллагаа | Хариуцах эзэн ба хугацаа | Хичээлийн хоцрогдлыг нөхөхөд хэрхэн дэмжлэг болохыг тодорхойлох |
|---|---|---|---|
| | | | |

*Жич: Тухайн төслийг хэрэгжүүлэхэд ашиглах аргазүй, аргачлалыг бүдүүвч зураглалаар илэрхийлж болно.*

**Хэсэг IV.** Зардлын задаргаа (НӨАТ орсон үнэ)

| Зардлын төрөл | Хэмжих нэгж | Тоо | Нэг бүрийн үнэ, төг | Нийт үнэ, төг | Тус бүрд нь хүрэх үр дүнг бичнэ. (Хүүхдэд ямар бодит үр дүн авчрах, ямар чадварыг эзэмшүүлэх) |
|---|---|---|---|---|---|
| Сургалтын хэрэглэгдэхүүн, бусад | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| материалын худалдан авалт | | | | | |
| Зөвлөх үйлчилгээний зардал | | | | | |
| Сургалтын зардал | | | | | |
| Үйл ажиллагааны зардал | | | | | |
| **НИЙТ** | | | | | |

**Хэсэг V.** Төслийн тогтвортой байдал (товч бичнэ)

Уг төслийг хэрэгжүүлж дууссаны дараа үр дүн нь цаашид тогтвортой үргэлжлэх эсэх тухай бичнэ. Өөрөөр хэлбэл, төсөл дуусгавар болсон ч төслийн үйл ажиллагааг цаашид үргэлжлэн хэрэгжинэ гэсэн үг.

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр:

| |
|---|
| Дарга, Захирлын нэр........................ /Гарын үсэг..................................../ |

| | | |
|---|---|---|
| Төслийг боловсруулсан: | Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн эсвэл Бага ангийн сургалтын менежер, эсвэл багш, эцэг эхийн нэр /....................................../<br>Гарын үсэг.................................... | Огноо:<br>..........он........сарын......өдөр |

ТАМГА

# ХАВСРАЛТ Г.

## ТӨСЛИЙН ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

Уг тайланг 2 хуудсанд багтаан бичнэ.

| | |
|---|---|
| Аймаг, нийслэл: | |
| Сум, дүүрэг: | |
| ЕБС (БСУГ, хэлтэс)-ийн нэр хаяг: | |
| Захирал, дарга, мэргэжилтний  овог, нэр | |
| Төслийн нэр: | |
| Төслийн үр шим хүртэгчдийн тоо: | |

### 1. Төслийн үйл ажиллагааны биелэлт

| Төлөвлөсөн үйл ажиллагаа | Биелэлтийн хувь | Үр дүн, бэрхшээл, сургамж |
|---|---|---|
| | | |

### 2. Худалдан авах үйл ажиллагааны мэдээлэл

- Үнэлгээний хороо байгуулсан эсэх
  - ☐ Тийм
  - ☐ Үгүй

  Үнэлгээний хорооны тушаалын дугаар:…………………
- Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, шийдвэр байгаа эсэх
  - ☐ Тийм
  - ☐ Үгүй

| № | Гэрээний дугаар | Гэрээний утга | Гэрээний дүн | Худалдан авах арга | Гэрээ байгуулсан огноо | Гэрээлэгчийн нэр, улсын бүртгэлийн № |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |

### 3. Санхүүгийн зарцуулалтын тайлан

*3а. Дансны хуулгыг сканердаж оруулна.*
*3б. Зарцуулалтын тайланг доорх загвараар бөглөж ируүлнэ.*

Гүйлгээний жагсаалт, холбогдох баримтыг дараах байдлаар ируүлнэ.

| Санхүүжилт | | | Төрийн сан дах гүйлгээний жагсаалт | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зардлын төрөл | Төлөвлөсөн | Зарцуулсан | Гүйлгээний дүн | Баримтын төрөл | Баримтын дугаар | Огноо | Дүн | Төлбөр хүлээн авагчийн нэр |
| Худалдан авалт | | | | | | | | |
| | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Сургалт | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Үйл ажиллагаа | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Нийт | - | - | - | | | | | |

БӨГЛӨХ ЖИШЭЭ:

| Санхүүжилт | | | Төрийн сан дах гүйлгээний жагсаалт | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зардлын төрөл | Төлөвлө-сөн | Зарцуулсан | Гүйлгээний дүн | Баримтын төрөл | Барим-тын дугаар | Огноо | Дүн | Төлбөр хүлээн авагчийн нэр |
| Худалдан авалт | 5,000,000 | 4,500,000 | 500,000 | Нэхэмжлэх | 25 | 2021.10.17 | 500,000 | АБВ ХХК |
| | | | | Зарлагын баримт | 80 | 2021.10.20 | 500,000 | |
| | | | 2,000,000 | Нэхэмжлэх | 40 | 2021.09.20 | 2,000,000 | ААА ХХК |
| | | | | Зарлагын баримт | 85 | 2021.09.25 | 2,000,000 | |
| | | | | Гэрээ | 2 | 2021.09.01 | 2,000,000 | |
| | | | 2,000,000 | Нэхэмжлэх | 1 | 2021.11.20 | 2,000,000 | БББ ХХК |
| | | | | Зарлагын баримт | 91 | 2021.11.25 | 2,000,000 | |
| | | | | Гэрээ | 5 | 2021.11.01 | 2,000,000 | |

***3в. Зураг.*** Төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг ***оновчтой*** харуулсан 3-4ш зураг хавсаргана. /зураг, бичлэгийн хэмжээ нь цахимаар илгээх боломжтой байх/

# ХАВСРАЛТ Д.

## БАРАА, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХАД ҮНИЙН САНАЛ АВАХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ШАЛГАРУУЛАХАД АШИГЛАХ ЗАГВАР

Худалдан авах ажиллагаа тус бүр дээр гурван үнийн санал авч доорх байдлаар тэмдэглэнэ:

| СУРГУУЛЬ: | | | ЗАХИРАЛ: | | |
|---|---|---|---|---|---|
| Улирал эхлэх __________________ (он сар өдөр)<br>Дуусах ___________ (он сар өдөр) | | | | | |
| | Улиралд худалдан авсан бараа, үйлчилгээний нэр | Үнийн санал | Нийлүүлэгчийн нэр | Үнэ | Он сар өдөр |
| 1 | | 1 | | | |
| | | 2 | | | |
| | | 3 | | | |
| | Шалгарсан нийлүүлэгч: | | | | |
| | Улиралд худалдан авсан бараа, үйлчилгээний нэр | Үнийн санал | Нийлүүлэгчийн нэр | Үнэ | Он сар өдөр |
| 2 | | 1 | | | |
| | | 2 | | | |
| | | 3 | | | |
| | Шалгарсан нийлүүлэгч: | | | | |

Тайлбар: Үнийн саналын эх хувийг хавсаргана.

| | Зөвлөх үйлчилгээ | Үнийн санал | Зөвлөхөд нэр дэвшигчид | Үнэ | Он сар өдөр |
|---|---|---|---|---|---|
| 1 | | 1 | | | |
| | | 2 | | | |
| | | 3 | | | |
| | Шалгарсан нийлүүлэгч: | | | | |
| | Улиралд явуулсан сургалт | Үнийн санал | Сургалт явуулсан байгууллага, хүний нэр | Үнэ | Он сар өдөр |
| 2 | | 1 | | | |
| | | 2 | | | |
| | | 3 | | | |
| | Шалгарсан байгууллага: | | | | |

# ХАВСРАЛТ Е.

## ГЭРЭЭНИЙ ЗАГВАР: БШУЯ, БСУГ, СУРГУУЛЬ ХООРОНД БАЙГУУЛАХ

БАТЛАВ. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.БАТБААТАР

СУРГУУЛИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙГ
САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭРЭЭ
Дугаар ..............

2021 оны ... дүгээр сарын ... -ний өдөр Улаанбаатар хот

Нэг талаас Боловсрол, шинжлэх ухааны яам (цаашид “санхүүжүүлэгч” гэх)-ыг төлөөлж, Боловсрол, шинжлэх ухааны яамны ........................................, нөгөө талаас .................... аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар (цаашид “хэрэгжүүлэгч” гэх)-ыг төлөөлж, Боловсрол, соёл, урлагийн газрын дарга ......................... нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож, Боловсрол, шинжлэх ухааны Сайдын 2021 оны .... дугаар сарын .....-ны өдрийн Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг санхүүжүүлэх тухай ............. дүгээр тушаалыг үндэслэн энэхүү ГЭРЭЭ (цаашид “гэрээ” гэх)-г байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, эрх, үүргийг тогтооход энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн тавдугаар шатны хэрэгжилтийг зохион байгуулахад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн гарын авлагын хүрээнд хийж гүйцэтгэнэ.

1.3 Санхүүжүүлэгч нь гэрээний нэгдүгээр хавсралтад заасан сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн тавдугаар шатны төслийг хэрэгжүүлэхэд зориулагдах ....................... /......................../ төгрөгийг санхүүжүүлнэ.

1.4 Хэрэгжүүлэгч нь “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээ”-г сургуулиас ирүүлсэн төслийн саналын дагуу энэхүү гэрээний нэгдүгээр хавсралт ёсоор сургуулиудтай байгуулна.

1.5 Санхүүжүүлэгч нь Олон улсын хөгжлийн ассоциацитай (цаашид “Банк” гэнэ)-тай байгуулсан зээлийн гэрээний дагуу зөвшөөрөгдөх зардлын зүйл ангийн хүрээнд санхүүжүүлэх ба төслийн саналд зааснаас бусад зардлыг санхүүжүүлэхгүй.

1.6 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх).

- Нэгдүгээр Хавсралт /БШУ-ы Сайдын 2021 оны .... дугаар сарын ....-ны өдрийн ..... тоот тушаал/
- Хоёрдугаар Хавсралт /Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн гарын авлага/

### Хоёр. Талуудын хүлээх эрх, үүрэг

**2.1 Санхүүжүүлэгч нь дор дурдсан эрх, үүрэг хүлээнэ:**

2.1.1 Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн тавдугаар шатны хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.

2.1.2 Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн тавдугаар шатанд бага боловсролын чанарыг ахиулахад туслах зорилгоор хэрэгжих төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцно.

2.1.3 ................ аймгаас сонгогдсон сургуульд хуваарилагдсан нийт санхүүжилтийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын Төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн ................. тоот дансанд 2021 оны .... дугаар сарын ....-ны дотор шилжүүлнэ.

2.1.4 Төслийн хэрэгжилтийн явцад илэрсэн зөрчлийг арилгуулах ба зөрчлийг арилгаагүй тохиолдолд санхүүжилтийг буцаан татах хүртэл арга хэмжээ авна.

2.1.5 ......................... аймгийн сургуулиудын төслийн хэрэгжилтийн эцсийн тайланг хэрэгжүүлэгчээс хүлээн авч, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргана.

2.1.6 Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилтийн талаар олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулна.

2.2 Хэрэгжүүлэгч нь дор дурдсан эрх, үүрэг хүлээнэ:

2.2.1 Орон нутгийн түвшинд сургуулиуд төслөө хэрэгжүүлэхэд нь төрийн захиргааны болон мэргэжлийн удирдлагаар ханган, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

2.2.2 Хэрэгжүүлэгч нь сургуулийн захиралтай "Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээ" байгуулан ажиллана.

2.2.3 Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн төслийн санхүүжилтийг 2021 оны .... дүгээр сарын ....-ний дотор сумын Төрийн сан дахь сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд нэгдүгээр хавсралтад заасан хуваарийн дагуу шилжүүлнэ.

2.2.4 Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийг дүгнэж, санхүүжүүлэгчид мэдээлж, тайлагнана.

2.2.5 Төслийн санхүүжилтийг зориулалтын бусаар ашиглаж байгаа сургуулиудын санхүүжилтийг буцаан татах хүсэлтийг санхүүжүүлэгч талд гаргана.

2.2.6 Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулна.

2.2.7 Төсөл хэрэгжүүлж буй сургуулиудаас ирүүлсэн эцсийн тайланг нэгтгэж, сургууль бүрээр PDF файл болгох ба төслийн хугацаа дуусгавар болсон тухай бүрд цахимаар Боловсрол, шинжлэх ухааны яам болон "Боловсролын чанарын шинэчлэл" төсөлд хүргүүлнэ. Эх хувийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газарт хадгална.

2.2.8 Төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

## Гурав. Бусад зүйл

3.1 Гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд, талууд харилцан тохиролцож, энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна. Нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

3.2 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.

## Дөрөв. Гэрээний хугацаа

4.1. Энэхүү гэрээг 2021 оны ... дугаар сарын ....-ны өдөр хүртэлх хугацаагаар байгуулав.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

САНХҮҮЖҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

__________________________ _______________________

/гарын үсэг / /гарын үсэг/

.............., БШУЯ-ны Санхүү,
эдийн засгийн газрын дарга

_______________________
/албан тушаал/

## СУРГУУЛИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

**Дугаар** ............

2021 оны ... дүгээр
сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас ........................ аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар (цаашид “БСУГ” гэх)-ыг төлөөлж, БСУГ-ын дарга ..........................................., нөгөө талаас ............................ аймгийн ........................ сумын ерөнхий боловсролын сургууль (цаашид “Төсөл хэрэгжүүлэгч” гэх)-ийг төлөөлж, захирал ............ овогтой ............... нар (хамтад нь “Талууд” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу сургуулийн тэтгэлэгт төслийг (цаашид “төсөл” гэх) хэрэгжүүлэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан үүрэг хүлээх, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн нийт санхүүжилт болох ............. /............................./ төгрөгийг “...................................” төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

1.3. Төсөл хэрэгжүүлэгч нь Олон улсын хөгжлийн ассоциацаас (цаашид “Банк”гэнэ) өгсөн санхүүжилтийг төслийн зөвшөөрөгдсөн зардлын хүрээнд буюу нэгдүгээр хавсралтад заасан төслийн үйл ажиллагаанд зарцуулах ба төсөлд зааснаас бусад зардлыг санхүүжүүлэхгүй.

1.4. Төсөл хэрэгжүүлэгч нь сургуулийн тэтгэлгийн төсөлд заасан үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу 20.... оны ....-р сарын ....хүртэл хугацаанд багтаан гүйцэтгэнэ. Хоёр тал бичгээр тохиролцсоны дагуу гэрээний хугацаанд өөрчлөлт оруулж болно.

1.5. Талууд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн төсөлд тусгагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөг мөрдөн ажиллах бөгөөд төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах шаардлагатай бол БСУГ-аар дамжуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд бичгээр мэдэгдэн зөвшөөрөл авна.

1.6. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй нэг хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).

- Хавсралт №1 /Сургуулийн тэтгэлгийн төслийн санал/
- Хавсралт №2 /Төсөл хэрэгжүүлэх гарын авлага/
- Хавсралт №3 /Авлига, хууран мэхлэхээс сэргийлэх, данс бүртгэл, хяналт, аудиттай холбоотой Дэлхийн банкны заалт/

## Хоёр. Талуудын хүлээх үүрэг, хариуцлага

**2.1. БСУГ-ын хүлээх эрх, үүрэг, хариуцлага**

2.1.1. Тэтгэлэгт хөтөлбөрийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төслийн хэрэгжилтийн талаар тухайн орон нутагтаа сургалт зохион байгуулж, шаардлагатай мэдээллээр хангах;

2.1.2. Тэтгэлэгт хөтөлбөрийн төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хяналт тавих, зөвлөн туслах;

2.1.3. Төслийн санхүүжилтийн байдалд байнгын хяналт тавьж, санхүү болон үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчлийг арилгаагүй тохиолдолд санхүүжилтийг зогсоох саналыг холбогдох газарт хүргүүлэх;

2.1.4. Сургуулийн тэтгэлэгийн төслийн хүрээнд хийсэн худалдан авалт нь холбогдох хууль, журмыг зөрчсөн тухайлбал зах зээлийн үнээс өндөр үнийн дүнгээр худалдан авалт хийсэн, хуучин бараа худалдан авсан зэрэг техникийн шаардлагад нийцэхгүй худалдан авалт хийсэн нь тогтоогдсон тохиолдолд гэм буруутай этгээдээр хохирлыг барагдуулах арга хэмжээ авах;

2.1.5. Төслийн үйл ажиллагааны эцсийн тайланг хянан, цахим хэлбэрээр БШУЯ болон “Боловсролын чанарын шинэчлэл” төсөлд хүргүүлэх;

2.1.6. Төслийн санхүүжилтийг аймгийн Төрийн сан дахь БСУГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд 100 хувь буюу ................ /...................................................... / төгрөгийг 2021 оны ....-р сарын ....-ны дотор олгоно.

**2.2. Төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх эрх, үүрэг, хариуцлага**

2.2.1 Төслийг төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх;

2.2.2 Төслийн хэрэгжилтийн эцсийн тайлан болох санхүү, үйл ажиллагаа, худалдан авалтын тайланг 20.... оны ....-р сарын ....–ний дотор аймгийн БСУГ-т хүргүүлэх;

2.2.3 Төслийн санхүүжилтийг төслийн төлөвлөсөн үйл ажиллагаанд зарцуулах;

2.2.4 Төслийн хүрээнд худалдан авсан тавлига, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл зэргийг тухайн сургууль буюу орон нутгийн өмч, хөрөнгөд хүлээн авч, зохих бүртгэлийг хийх;

2.2.5 Төслийн хэрэгжилтийн явцад тухайн сургуулийн удирдах зөвлөл, эцэг эх, сурагчид, багш нарын оролцоог хангах;

2.2.6 Тухайн аймгийн БСУГ-аас хийх мониторингийн ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах үйл ажиллагаагаа тайлагнах;

2.2.7 БСУГ-аас зохион байгуулж буй сургалтад идэвхтэй оролцох, олж авсан мэдлэгээ бусдад түгээх, төслийн хэрэгжилтэд ахиц гаргах;

2.2.8 Төрийн сангийн холбогдох дүрэм, журмын хүрээнд төслийн санхүү, болон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулах;

2.2.9 Бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын материалууд, төлбөрийн даалгавруудыг сургууль нь төсөл дуусгавар болсноос хойш хоёр жилийн хугацаанд хадгална.

## Гурав. Бусад зүйл

3.1. Төсөл хэрэгжүүлэгч нь яамнаас бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн бусдад шилжүүлэхийг хориглоно.

3.2. Төсөл хэрэгжүүлэгч нь Дэлхийн банкны худалдан авалт, ажил үйлчилгээг сонгон шалгаруулах журам болон Хавсралт №3 дахь заалтыг баримтална.

3.3. Хэрвээ гэрээний хэрэгжилтийн аль нэг үе шатанд тендерт оролцогч, нийлүүлэгч, гэрээт этгээд болон зөвлөхүүд зэрэг банкны санхүүжилт авч буй гэрээт этгээд хориотой үйлдэлд хамрагдсан тохиолдолд гэрээг цуцлана.

3.3. Гэрээнд оруулах өөрчлөлтөөс үүдэн гарах нэмэлт зардлыг тэтгэлэг олгогч тал хариуцахгүй. Энэхүү гэрээнд өөрчлөлт оруулахын өмнө Банкнаас бичгээр зөвшөөрөл авна.

**БСУГ-ыг төлөөлж:**

................................ /гарын үсэг/

................................../нэр/
.............. аймгийн БСУГ-ын дарга

**Төсөл хэрэгжүүлэгчийг төлөөлж:**

................................ /гарын үсэг/

................................../нэр/
........................ сургуулийн захирал

## Авлига, хууран мэхлэхээс сэргийлэх, данс бүртгэл, хяналт, аудиттай холбоотой Дэлхийн банкны заалт

### 1. Зорилго

1.1 Банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төслөөс санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны хувьд Банкны авлигын эсрэг журам болон энэхүү хавсралтыг дагаж мөрдөнө.

### 2. Тавигдах шаардлага

2.1 Банкнаас санхүүжүүлж буй гэрээний хүрээнд Зээлдэгч (Банкны зээлээс ашиг хүртэгсдийг оролцуулан), тендерт оролцогчид, ханган нийлүүлэгчид, гүйцэтгэгч, зөвлөхүүд, тэдгээрийн төлөөлөгчид (энэ тухайгаа мэдэгдсэн эсвэл мэдэгдээгүй), ажилтнууд, туслан гүйцэтгэгчид, үйлчилгээ үзүүлэгчид болон нийлүүлэгчид худалдан авах ажиллагаа болон тэдгээр гэрээг хэрэгжүүлэх явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг ханган ажиллахыг шаардах бодлогыг Банк баримталдаг.

2.2 Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх үүднээс Банк:

a. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх нэр томьёог доорхи байдлаар тодорхойлно. Үүнд:
(i) “авлигын үйлдэл” гэж бусад талуудын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд шууд буюу шууд бус хэлбэрээр аливаа төрлийн үнэ бүхий зүйлийг санал болгох, өгөх, хүлээн авах, авахыг санаархахыг хэлнэ;
(ii) “хууран мэхлэх үйлдэл” гэж санхүүгийн буюу бусад ашиг олох эсвэл үүрэг хариуцлагаас зугтахын тулд санаатай буюу санамсаргүйгээр төөрөгдүүлэх эсвэл төрөгдүүлэхийг оролдох аливаа үйлдлийг хэлнэ;
(iii) “хуйвалдах үйлдэл” гэж хоёр буюу түүнээс дээш талууд зүй бус зорилгод хүрэхээр үгсэн тохирох, түүний дотор бусад талуудын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зэргийг хэлнэ;
(iv) “дарамтлах үйлдэл” гэж нөгөө этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа этгээдэд буюу түүний эд хөрөнгөнд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулах, эсвэл хор хохирол учруулахаар заналхийлэхийг хэлнэ;
(v) “саад учруулах үйлдэл” гэж

(а) Авлига, хууран мэхлэх, дарамтлах буюу хуйвалдах зэрэг үйлдлийн талаар гаргасан нэхэмжлэлээр Банкнаас хийж буй шалгалтанд зориудаар саад учруулах болон хяналт шалгалттай холбогдуулж мэдээлэл өгөхөөс татгалзах, хяналт шалгалтыг зогсоох үүднээс аливаа этгээдийг айлган сүрдүүлэх, дарамтлах, тавгүй байдалд оруулах, шалгалтын явцад нотолгоо болох баримт материалыг санаатайгаар устгах, хуурамч баримт үйлдэх, баримт материалыг орлуулах буюу нуун дарагдуулах болон шалгалт хийж буй хүмүүст худал мэдэгдэл хийх болон

(б) 2.2 (е) заалтын дагуу Банкны шалгалт болон хөндлөнгийн хяналт хийх явцад санаатайгаар саад учруулах зорилго бүхий үйлдлүүдийг хэлнэ.

b. Шалгарсан байгууллага, хувь хүн уг гэрээний төлөө өрсөлдөж байхдаа шууд буюу өөр этгээдээр дамжуулан авлига, хууран мэхлэх, хуйвалдах, дарамтлах, саад учруулах үйлдэлд оролцсон болохыг нь Банк тогтоосон бол уг зөвлөхийг шалгаруулахаас татгалзана;

c. Зээлдэгчийн төлөөлөгч буюу зээлээс ашиг хүртэгсэд нь худалдан авах ажиллагааны үед болон гэрээг хэрэгжүүлэх явцад авлига, хууран мэхлэх, дарамтлах, хуйвалдах, саад учруулах үйлдэлд оролцсон болохыг нь Банк тогтоосон, Зээлдэгч уг буруу үйлдлийг зогсоох талаар Банкны

шаардлагад нийцсэн зохих арга хэмжээг цаг тухайд нь аваагүй бол тухайн гэрээний санхүүжилтэнд зориулан зээлийн хөрөнгөнөөс хуваарилсан хэсгийг хүчингүй болгоно;

d. Компани эсвэл хувь хүнийг (i) Банкны санхүүжилттэй гэрээт ажилд шалгаруулах[1]; (ii) туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч болон нийлүүлэгч эсвэл үйлчилгээ үзүүлэгчээр нэр дэвшүүлэх[2]; (iii) Банкнаас аливаа хэлбэрийн зээл хүлээн авах, банкны санхүүжилттэй төслийг боловсруулах эсвэл хэрэгжүүлэхэд оролцох эрхийг Банкны авлигын эсрэг журмын дагуу тодорхойгүй эсвэл тогтоосон хугацаагаар хасах арга хэмжээ авч нийтэд зарлана.

e. Банк нь тендерт оролцогч, зөвлөхүүд, ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч, үйлчилгээ үзүүлэгчид болон нийлүүлэгч нараас банкны зээлээр санхүүжиж буй гэрээний гүйцэтгэл, тендерийн саналтай холбогдолтой өөрийн данс, бүртгэл, бусад баримт бичгийг шалгах, Банкнаас томилсон хөндлөнгийн аудитын байгууллагаар шалгуулах[3] боломжийг Банкинд олгох тухай заалтыг гэрээнд оруулахыг Банк шаардах эрхтэй.

f. Компани эсвэл хувь хүн, түүний туслан гүйцэтгэгчид нь худалдан авах ажиллагааг зохион байгуулах, гэрээлэгчийг сонгон шалгаруулах, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой данс, бүртгэл, бусад баримт бичгийг нягт нямбай, ойлгомжтой, системчилсэн байдлаар хадгалах үүрэгтэй.

g. Компани эсвэл хувь хүн, түүний туслан гүйцэтгэгчид нь хавсралтын 2.2 (e) дэх заалтын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, гэрээлэгчийг сонгон шалгаруулах, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой ажлын байр, данс, бүртгэл, бусад баримт бичгийг шалгах боломжийг Банк ба Банкнаас томилсон төлөөлөгчдөд олгох, тэдгээр данс, бүртгэлд Банкнаас томилсон хөндлөнгийн аудитын байгууллага аудит хийх боломжийг олгох үүрэгтэй. Компани эсвэл хувь хүн, түүний туслан гүйцэтгэгчид нь Банкны үзлэг шалгалт хийх, хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах эрхийг зөрчсөн аливаа хориотой үйлдэл гаргавал гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна (түүнчлэн Банкнаас авах арга хэмжээний журамд заасан бусад арга хэмжээг авна).

---

[1] Эргэлзээ үүсэхээс зайлсхийхийн тулд Банкны авлигын эсрэг журмын дагуу хориг арга хэмжээнд орсон этгээд гэрээ байгуулах эрхгүй гэдэгт дараах зүйлийг багтаан ойлгоно (үүгээр хязгаарлагдахгүй). Үүнд: (i) урьдчилсан шалгаруулалтад оролцох, тендерт оролцох хүсэлт гаргах, тендер, гэрээ байгуулахтай холбогдуулан шууд болон нэр дэвшсэн туслан гүйцэтгэгч, нэр дэвшсэн зөвлөх, нэр дэвшсэн үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, эсвэл үйлчилгээ эрхлэгч, (ii) одоо хүчин төгөлдөр байгаа гэрээнд нэмэлт, өөрчлөлт эсвэл хавсралт нэмж замаар гэрээ байгуулах зэрэг хамаарна.

[2] Нэр дэвшсэн туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч, нийлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгч нь (тухайн тендерийн баримт бичгийн онцлогоос шалтгаалан өөр өөр нэр ашиглагдаж болно) (i) тусгайлсан, маш чухал мэдлэг, туршлагатай байх ба тэдгээр нь тендерт оролцогчийг тухайн тендерийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангахад нөлөөлөх, мөн урьдчилсан сонгон шалгаруулалтын явцад оролцсон байх, эсвэл (ii) Зээлдэгчийн зүгээс томилсон байна.

[3] Үзлэг шалгалт нь ихэвчлэн эрэн сурвалжлах шинж чанартай (өөрөөр хэлбэл, магадлан тогтоох) байдаг. Үүнд, залилан мэхлэх, авлигын шинжтэй байж болзошгүй гэх мэдэгдэл хүлээж авсан зэрэг тодорхой асуудлын ул мөрөөр Банк эсвэл Банкнаас томилсон этгээдүүд тохирох механизмыг ашиглан бодит мэдээлэл цуглуулах замаар үзлэг шалгалт, аудит хийх үйл ажиллагааг хэлнэ. Дээрх үйл ажиллагаанд дараах зүйл багтана (үүгээр хязгаарлагдахгүй): компани эсвэл хувь хүний данс, санхүүгийн бүртгэл болон холбогдох мэдээлэлтэй танилцах, шалгах, холбогдох хуулбарыг үйлдэх; үзлэг шалгалт, аудитад хамааралтай гэж үзсэн бусад бичиг баримт, мэдээлэл, мэдээллийг олж авах, шалгах (цаасан болон цахим хэлбэрээр), холбогдох хуулбарыг үйлдэх; ажилтнууд болон холбогдох бусад хүмүүстэй ярилцлага хийх; бие махбодийн үзлэг, газар дээр нь очиж үзэх; мэдээллийг баталгаажуулах зорилгоор гуравдагч этгээдээс мэдээлэл авах.

# ХАВСРАЛТ Ё.

## ТӨСЛИЙН САНАЛЫН ЖИШЭЭ - 1

**Сургуульд зориулсан төсөл:**

**Төслийн нэр:** Номын баатрууд

**Зорилго:** Мэдээллийн технологийн шийдлийг ашиглан сурагчдын унших чадварыг хөгжүүлэх

**Үйл ажиллагаа:**

- Ангийн номын санд байгаа номыг түүвэрлэн багш анги бүрээр унших номын жагсаалт бэлтгэж, сурагчдад танилцуулна. Уншаад ойлгох чадварыг ахиулахаар зорино;
- ЭГРА арга зүйн эхэд асуулт зохиох аргачлалаа ашиглан, багш уншаад ойлгох чадвар хөгжүүлэх асуултыг ном бүрээр бэлтгэнэ;
- Багш асуултаа Google sheet гэдэг програм ашиглан сургуулийн номын сангийн компьютер дээр шивж оруулна;
- Сурагч номоо бие даан уншсаны дараагаар завтай үедээ номын сангийн компьютер дээр ирж суугаад асуултад хариулж, мэдээллээ шивнэ;
- Багш сурагчийн хариултаас хянан үзэж номоо уншаад ойлгосныг шалгана;
- Хөтөлбөрийн төгсгөлд хэн хамгийн олон номын асуултад хариулсныг дүгнэж болно. Бүх сурагчийг оролцуулахыг эрхэмлэх ёстой.

# ТӨСЛИЙН САНАЛЫН ЖИШЭЭ - 2

**БСУГ, хэлтсийн мэргэжилтэнд зориулсан жишээ:**

**Төслийн нэр:** БСУГ, хэлтсээс аймаг дүүргийн хэмжээнд үнэлгээний цахим програм турших

**Зорилго:** Аймаг дүүргийн хэмжээнд нэг програмын брэнд болгон сонгож аваад бүх багш туршин хэрэгжүүлэх

**Үйл ажиллагаа:**

- БСУГ, хэлтсээс багш нарын хэрэгцээг судлан тодорхойлж, үнэлгээг цахимжуулах шаардлагыг олж тогтооно. Шаардлагадаа үндэслэн холбогдох сургалтын байгууллага, сургагч багшийг судлан тодорхойлно. Жишээ нь, мэдээллийн технологийн боловсролоор мэргэшсэн байгууллага, эсвэл өөр аймаг дүүргээс туршлагатай багш мэргэжилтэн байж болно;

- Тухайн мэргэшсэн сургагч багш нараас үнэлгээний шинэ арга зүйн програм нэвтрүүлэх сургалтыг бүх багшид явуулах, програмаа зохиох, нутагшуулах ажлыг багш анртай хамтран гүйцэтгэж болно. Ялангуяа, хичээлээр хоцрогдож буй сурагчдад зориулан технологийн шийдлийг ашиглан багшийн ажлыг хөнгөвчлөх арга замыг эрж хайна. Эцэст нь сурагч өөрөө компьютер дээр ажиллаад мэдлэгээ шалгадаг аргыг нэвтрүүлэх гэх мэт;

- Програм хийгдэж, багш нарыг сургасны дараагаар сургууль бүр дээр туршилтыг сургууль бүр дээр үргэлжүүлэх, мониторинг хийх, туршлагаа солилцох, програмыг баяжуулах зэрэг үйл ажиллагаанууд үргэлжлэх жишээтэй.

# ХАВСРАЛТ Ж.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС

**Мэдээллийн технологийг ашиглах хүрээнд олон улсын зарим туршлагаас:**

**1. Замби: Багш нар интерактив арга зүйд суралцах “iAct” төсөл**
https://iact.info/iact-in-zambia/

iAct гэдэг нь интерактив суралцахуй ба багшлахуй гэсэн үг. iAct төслийн хүрээнд боловсруулсан багшлахуйн арга зүй нь багшийн ажлыг цоо шинэ түвшинд хүргэжээ. iAct төслийн дагуу багш нар сургалтдаа мэдээллийн технологи ашиглах цогц сургалтад хамрагджээ. Багш нар бие даан сургалтад хамрагдах замаар сайн дурын багш нарын чадавхыг ахиулсан байна. iAct нь 4 модул бүхий тус бүр нь 5 долоо хоног үргэлжлэх хөтөлбөр ажээ.

**2. “OER4Schools” буюу Сургуульд зориулсан нээлттэй эх сурвалжууд**
http://oer.educ.cam.ac.uk/wiki/OER4Schools

Багш нар ажлын байран дээр зөөврийн мэдээллийн технологи хэрэгсэл ашиглан чадвараа ахиулах онлайн сургалтын материал. Зорилго нь багш нарын таблет, нөүбүүк, е-ном уншигч, нээлттэй эхүүд ашиглах чадварыг сайжруулах замаар математик ба байгалийн ухааны хичээлийг интерактив хэлбэрт оруулах арга замуудыг эзэмшүүлэх явдал юм.

Энэхүү сургалтыг Африкийн зарим оронд туршиж амжилттай хэрэгжүүлжээ. Энэ нь мэдээллийн технологийн хэрэгсэл дутмаг, алслагдсан нутагт тохирсон бөгөөд нээлттэй эх сурвалж хэлбэрээр байршсан учир хүн бүхэн ашиглах боломжтой. 28 удаагийн 2 цагийн хичээлтэй. Агуулга нь интерактив хичээлийн зарчмууд, бүлгээр ажиллах, асуулт тавих, үнэлгээ хийх, туршилт явуулах зэргийг багтаана. Видео хэлбэртэй байна.

**3. Шинэ Зеланд: “суръя –бүтээе – бусдад түгээе”**

Нэгэн мужийн бүх сургууль хамтдаа “суръя – бүтээе – бусдад түгээе” нэртэй төслийг хэрэгжүүлжээ. Үүнд:

- Сурья: Сурагч бүр уншиж, бичиж, тоолж сурна.
- Бүтээе: Сурагч бүр сурснаа бусдадаа толилуулах бүтээл төсөл хэрэгжүүлнэ. Хэсэг сурагч нийлэн Нелсон Манделагийн тухай дуу зохиожээ.
- Бусдад түгээе: Тэд төсөлт ажлаар зохиосон зүйлээ заавал бусдадаа түгээнэ. 2 дугаар ангиас компьютер ашиглаж эхэлнэ. WordPress ашиглан блог ажиллуулдаг байна.

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС

**4. Австрали: Инновац**

“Инновацийн нүд” хэмээх програм ашиглан, бүх сурагч онлайнаар хамтран ирээдүйн сургуулийн төсөөлөл боловсруулжээ.

- Багаар ажиллах чадвар дээшилнэ. Багш чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэнэ. Сурагч бүр компьютертэй ба төсөлт ажлаа хийж бусадтайгаа хамтран ажиллана.
- Сурагчид багштайгаа хамтран интерактив сургалтын арга зүйн санааг гаргажээ.

**5. АНУ: “Миний интерактив анги” төсөл**

**А. Beneylu School нэртэй програм ашиглах**
https://beneylu.com/school/us/

Бага ангийн нэг багш сургалтаа хэрхэн онлайн явуулдаг аргаа хуваалцаж байна. Интернэтэд суурилсан Beneylu School програм ашиглан, компьютер, таблет зэрэг зөөврийн төхөөрөмж дээр ажиллах эх сурвалжаар дижитал анги хичээллүүлж хэвшжээ. Багшийн ажлын зарим жишээг харуулбал, долоо хоног бүр багш Ажлын төлөвлөгөө гаргаж доорх байдлаар оруулна. Сурагчид хараад ажиллана.



## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС

**Б. Beneylu School ангид:**
Ангид хичээл ороход мөн ашиглаж, хүүхэд бүр програм ашиглан даалгавар гүйцэтгэнэ. Багш даалгаврыг харна, санал өгнө. Эцэг эхчүүд хүүхдийнхээ хийсэн даалгаврыг харна.

**В. Е-хичээлүүд**
Beneylu School дээр цахим хичээл видео хадгалагдана. Багш сурагчийн гүйцэтгэлийг шалгах тоглоомын аргыг өргөн ашиглана. Тоглоомын аргаар сурч, мэдлэгээ шалгуулах боломжтой.

**Д. Мэссэж чэллэнж**
Багш мэссэж чэллэнж зарладаг. Календарь зохионо: adventmyfriend.com. Блог дээр багш мэдээлэл оруулж, сурагчид мэссэжээр ахриулах арга. Сурагч мөн видео, эх зэргийг мэссэжээр илгээнэ. Бүх мэдээлэл хадгалагдана. Мөн Beneylu School ашиглаж буй бусад сургуулийнхантай харилцаж болно. Сурагчид нээлттэй блог руу орж мэдээлэл солилцоно. Хамтдаа төсөлт ажил бүтээнэ.

**Е. Эцэг эхтэй ажиллах**
Эцэг эхчүүд хүүхдийнхээ бүх хийсэн ажлыг харах боломжтой.



# ХАВСРАЛТ 3.

## ЭХ СУРВАЛЖИЙН КАТАЛОГ

### НЭГ. БАГА БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ОНЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

## ТЕЛЕ ХИЧЭЭЛ

www.econtent.edu.mn






## ХУВИЛБАРУУД

АПП ✓

ВЭБ

МАТ ✓

МОНГОЛ ХЭЛ ✓

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ ✓

## АШИГЛАХ БОЛОМЖ

Бага боловсролын агуулгын хүрээн дэх хичээлийн сэдвүүдийг бүгдийг агуулсан бөгөөд суралцагчдад суурь мэдлэг олгоно

Бага боловсролын хөтөлбөрийн агуулгын хүрээнд нийт 992 хичээл

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✓ |
| ЭЦЭГ ЭХ | ✓ |
| АНГИ | I-V |

## БУСАД

| | |
|---|---|
| ИНТЕРАКТИВ ЭСЭХ | ✗ |
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | ҮНЭГҮЙ |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ҮГҮЙ |

## ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛҮҮД

https://econtent.edu.mn/interactives/EBS




## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МАТ

МОНГОЛ ХЭЛ

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

Математик (1-10 хүртэлх тооны бүтэц бататгах, 2, 5, 10-р үржүүлэх, 100 дотор аравт хэтрүүлэн нэмэх, хасах, мэдэгдэхгүй байгаа гишүүнийг олох)

Монгол хэл (эгшиг үсэг, үгийн утгыг ялгаж сурах)

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✓ |
| ЭЦЭГ ЭХ | ✓ |
| АНГИ | I-V |

## БУСАД

| | |
|---|---|
| ИНТЕРАКТИВ ЭСЭХ | ✓ |
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | ҮНЭГҮЙ |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ҮГҮЙ |

## SURAAD.MN САЙТ

www.suraad.mn




## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МАТ

МОНГОЛ ХЭЛ

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Суралцагч III-V ангийн математикийн хичээлийг бие даан судлах боломжтой
- Математикийн хичээлийн зарим мэдлэгийг бие дааж суралцах

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ

СУРАГЧ

ЭЦЭГ ЭХ

АНГИ III-V

## БУСАД

ИНТЕРАКТИВ ЭСЭХ

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ: 1 сар 20к, 3 сар 50к, 6 сар 80к, 1 жил 150к

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ: ТИЙМ

# MATHSHOP ПРОГРАМ

www.mathshop.mn




## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МАТ

МОНГОЛ ХЭЛ

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

Суралцагчид түвшингээ тогтоох, цаашид хянах боломжтой. Англи, Монгол хэлний сонголттой.

Математикийн энгийн, дунд, ахисан түвшнээр ангилсан хичээлүүд багтсан

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ

СУРАГЧ

ЭЦЭГ ЭХ

АНГИ I-V

## БУСАД

ИНТЕРАКТИВ ЭСЭХ

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1 сар 5к, 1 жил 50к

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ ТИЙМ

# KHAN ACADEMY

https://mn.khanacademy.org/




## ХУВИЛБАРУУД

АПП ✗

ВЭБ

МАТ ✓

МОНГОЛ ХЭЛ ✗

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ ✗

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Тоо тоолол, Нэмэх хасах үйлдлийн удиртгал, 20 дотор +/-, 100 дотор +/-, 1000 дотор +/-, Хэмжилт ба өгөгдөл, Геометрийн хичээлтэй
- Суралцагч математикийн интерактив хичээлийг бие даан судална

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✓ |
| ЭЦЭГ ЭХ | ✓ |
| АНГИ | II-V |

## БУСАД

| | |
|---|---|
| ИНТЕРАКТИВ ЭСЭХ | ✓ |
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | ҮНЭГҮЙ |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ТИЙМ |

## IMATH

https://imath.mn/







## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МАТ

МОНГОЛ ХЭЛ

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

Тоо тоолол, Тэгшитгэл, Илэрхийлэл, Өгүүлбэртэй бодлого, Хэрчмийн арга, Угталцах хөдөлгөөн, Эсрэг чигийн хөдөлгөөн, Голын урсгалтай бодлогууд, Хэсгийн бодлого, Ажлын бодлого, Холимог бодлого, Процент гэх мэт

Суралцагч математикийн хичээлийг бие даан судална

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ

СУРАГЧ

ЭЦЭГ ЭХ

АНГИ I-V

## БУСАД

ИНТЕРАКТИВ ЭСЭХ

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1 жил 100к, 10+ сурагч 10%, 20+ сурагч 20%

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ ТИЙМ

# МАРЧААХАЙ - САЙТ

https://marchaakhai.mn/




## ХУВИЛБАРУУД

АПП ✗ | ВЭБ

МАТ ✓ | МОНГОЛ ХЭЛ ✓ | БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ ✗

## АШИГЛАХ БОЛОМЖ

Тоо тоолол, Тэгшитгэл, Илэрхийлэл, Өгүүлбэртэй бодлого, Хэрчмийн арга, Угталцах хөдөлгөөн, Эсрэг чигийн хөдөлгөөн, Голын урсгалтай бодлогууд, Хэсгийн бодлого, Ажлын бодлого, Холимог бодлого, Процент гэх мэт

Суралцагч математикийн хичээлийг бие даан судална

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✓ |
| ЭЦЭГ ЭХ | ✓ |
| АНГИ | I-II |

## БУСАД

| | |
|---|---|
| ИНТЕРАКТИВ ЭСЭХ | ✗ |
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | 1 жил 15к |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ТИЙМ |

## МАРЧААХАЙ - АПП

Android & iOS




## ХУВИЛБАРУУД

АПП ✓

ВЭБ

МАТ ✓

МОНГОЛ ХЭЛ ✓

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ ✗

## АШИГЛАХ БОЛОМЖ

Математик. Хасах, нэмэх үйлдэл, Дараалан хасах, нэмэх үйлдэл, Хүрд Монгол хэл- Цагаан толгой 35 үсэг Түүнчлэн ардын аман зохиол, танин мэдэхүйн мэдлэг авах боломжтой

Суралцагч гар утасны аппликейшн руу нэвтрэн өөрөө ашиглах боломжтой.

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✗ |
| СУРАГЧ | ✓ |
| ЭЦЭГ ЭХ | ✗ |
| АНГИ | I-II |

## БУСАД

| | |
|---|---|
| ИНТЕРАКТИВ ЭСЭХ | ✗ |
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | 1 жил багц 28к, 6 сар багц 15к |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ТИЙМ |

## TOBI - АПП

Android & iOS




## ХУВИЛБАРУУД



АПП



ВЭБ



МАТ



МОНГОЛ ХЭЛ



БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ 

СУРАГЧ 

ЭЦЭГ ЭХ 

АНГИ I-II

## АШИГЛАХ БОЛОМЖ

Цагаан толгойн 35 үсэг таних, Үг холбож унших

Суралцагч 35 үсгийг хэрхэн холбож, үг бүтээж уншихыг сурахаас гадна даалгаварт өгөгдсөн 33 улсаар аялангаа уншиж сурах боломжтой.

## БУСАД

ИНТЕРАКТИВ ЭСЭХ 

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 90 хоног 15к

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ ТИЙМ

## БАМБУУЛАЙ - АПП

iOS






## ХУВИЛБАРУУД

АПП ✓ | ВЭБ

МАТ ✓ | МОНГОЛ ХЭЛ ✓ | БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ ✗

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Цагаан толгойн 35 үсэг, Тоо тоолол, Өнгө, Дүрс, Амьтан, Үлгэр
  Төрөл бүрийн үлгэр сонсох боломжтой
- Суралцагч гар утасны аппликейшн руу нэвтрэн өөрөө ашиглах боломжтой.

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✗ |
| СУРАГЧ | ✓ |
| ЭЦЭГ ЭХ | ✗ |
| АНГИ | I-II |

## БУСАД

| | |
|---|---|
| ИНТЕРАКТИВ ЭСЭХ | ✗ |
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | 1 багц 3к |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ТИЙМ |

# ХОЁР. АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ МАТЕМАТИК, БАЙГАЛИЙН УХААНЫ МЭДЛЭГ ОЛГОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

## KHAN ACADEMY

https://www.khanacademy.org/ Android & iOS







## ХУВИЛБАРУУД

АПП ✓

ВЭБ

МАТ ✓

МОНГОЛ ХЭЛ ✗

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ ✓

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Байгалийн шинжлэл, математикийн хичээлийн сан
- Багш, сурагч, эцэг эхчүүд сайтад бүртгүүлж ашиглана
- Суралцагч гар утасны аппликейшнд нэвтрэн өөрөө ашиглах боломжтой.

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✓ |
| ЭЦЭГ ЭХ | ✓ |
| АНГИ | III-V |

## БУСАД

| | |
|---|---|
| ИНТЕРАКТИВ ЭСЭХ | ✓ |
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | ҮНЭГҮЙ |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ТИЙМ |

## KHAN ACADEMY KIDS

https://learn.khanacademy.org/khan-academy-kids/ Android & iOS







## ХУВИЛБАРУУД

| Хувилбар | |
|---|---|
| АПП | ✓ |
| ВЭБ | ✓ |
| МАТ | ✓ |
| МОНГОЛ ХЭЛ | ✗ |
| БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ | ✓ |

## АШИГЛАХ БОЛОМЖ

- 1-2 дугаар ангийн сурагчдад тохирсон тоглоомын аргаар суралцах хичээлийн сан
- Дагалдах видео хичээл, хэвлэмэл материалын сантай
- Суралцагч гар утасны аппликейшнд нэвтрэн өөрөө ашиглах боломжтой.

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✓ |
| ЭЦЭГ ЭХ | ✓ |
| АНГИ | I-II |

## БУСАД

| | |
|---|---|
| ИНТЕРАКТИВ ЭСЭХ | ✓ |
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | ҮНЭГҮЙ |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ТИЙМ |

## NATIONAL GEOGRAPHIC

https://www.nationalgeographic.org/education/resource-library/




## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МАТ

МОНГОЛ ХЭЛ

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

Байгалийн шинжлэлийн сонирхолтой хичээлийн сан

Багш нар интерактив хичээлийг төлөвлөх арга зүйд суралцах боломжтой

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ

СУРАГЧ

ЭЦЭГ ЭХ

АНГИ I-V

## БУСАД

ИНТЕРАКТИВ ЭСЭХ

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ ҮНЭГҮЙ

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ ТИЙМ

## E-LEARNING FOR KIDS

https://www.e-learningforkids.org/




## ХУВИЛБАРУУД

АПП ✗

ВЭБ ✓

МАТ ✓

МОНГОЛ ХЭЛ ✗

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ ✓

## АШИГЛАХ БОЛОМЖ

Байгалийн шинжлэл, математикийн хичээлийг Windows, iOS компьютерт суулган ашиглана

Нэмэлтээр сурагчдын мэдээллийн технологи, амьдрах ур чадвар, эрүүл мэндийн мэдлэгийг тэлэх боломжтой

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✓ |
| ЭЦЭГ ЭХ | ✓ |
| АНГИ | I-V |

## БУСАД

| | |
|---|---|
| ИНТЕРАКТИВ ЭСЭХ | ✓ |
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | ҮНЭГҮЙ |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ҮГҮЙ |

## EDUCATION.COM

https://www.education.com/




## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МАТ

МОНГОЛ ХЭЛ

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

Математикийн хичээлийг интерактив, тоглоомын аргаар удирдах боломжтой

Сурагчид сайт руу өөрсдөө нэвтрэн хичээллэх боломжтой

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ

СУРАГЧ

ЭЦЭГ ЭХ

АНГИ I-V

## БУСАД

ИНТЕРАКТИВ ЭСЭХ

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ ҮНЭГҮЙ

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ ТИЙМ

## K5 LEARNING

https://www.k5learning.com/




## ХУВИЛБАРУУД

✗ АПП

ВЭБ

✓ МАТ

✗ МОНГОЛ ХЭЛ

✓ БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Математикийн дадлага ажлын дэвтрийг хэвлэн ашиглах боломжтой
- Эцэг эх, багш нар сайтад бүртгүүлэх шаардлагагүй

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✓ |
| ЭЦЭГ ЭХ | ✓ |
| АНГИ | I-V |

## БУСАД

| | |
|---|---|
| ИНТЕРАКТИВ ЭСЭХ | ✗ |
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | ҮНЭГҮЙ |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ҮГҮЙ |

## MATH GAMES - АПП

Android & iOS




## ХУВИЛБАРУУД

- АПП ✓
- ВЭБ
- МАТ ✓
- МОНГОЛ ХЭЛ ✗
- БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ ✗

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Математикийн дасгал, даалгаврыг тоглоом тоглохтой адилхан гүйцэтгэнэ
- Эцэг эх, багш нар ашиглах боломжтой

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✓ |
| ЭЦЭГ ЭХ | ✓ |
| АНГИ | I-V |

## БУСАД

| | |
|---|---|
| ИНТЕРАКТИВ ЭСЭХ | ✓ |
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | ҮНЭГҮЙ |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ҮГҮЙ |

# ГУРАВ. БАГШИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧАДВАР, ЦАХИМ, ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ БОЛОВСРУУЛАХАД АШИГЛАХ БОЛОМЖТОЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

## BLENDED LEARNING

https://blended.org.uk/




## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МЭД. ТЕХ

БЛЭНДЭД АРГА

ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

Багш нар танхимын хичээлийг дижитал технологид суурилан ганцаарчилсан, лайв, цахим хэлбэрээр хичээл удирдах чадварт суралцана

Багш нар блэндэд арга зүйд суралцана

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ

СУРАГЧ

АНГЛИ ХЭЛ АНХАН ШАТ

## БУСАД

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ ҮНЭГҮЙ

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ ТИЙМ

## SEESAW (CLASS, FAMILY)

[https://web.seesaw.me/](https://web.seesaw.me/) iOS







## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МЭД. ТЕХ

БЛЭНДЭД АРГА

ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Багш нар танхимын хичээлийг дижитал технологид суурилан ганцаарчилсан, лайв, цахим хэлбэрээр хичээл удирдах чадварт суралцана
- Багш нар блэндэд арга зүйд суралцана

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ

СУРАГЧ

АНГЛИ ХЭЛ АНХАН ШАТ

## БУСАД

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ ҮНЭГҮЙ

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ ТИЙМ

## GOOGLE CLASSROOM

https://classroom.google.com/ Android & iOS







## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МЭД. ТЕХ

БЛЭНДЭД АРГА

ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Багш нар виртуал анги үүсгэн, цахим хичээл зохион байгуулах, сурагчид, тэдний эцэг эх, асран хамгаалагчидтай харилцах, даалгавар өгөх, үнэлгээ хийх боломжтой
- Багш нар gmail хаягаараа нэвтэрнэ

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ

СУРАГЧ

АНГЛИ ХЭЛ АНХАН ШАТ

## БУСАД

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ ҮНЭГҮЙ

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ ТИЙМ

## TEACHER LAB

[https://canopylab.com/teacherlab/](https://canopylab.com/teacherlab/) Android & iOS




## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МЭД. ТЕХ

БЛЭНДЭД АРГА

ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

- 40 гаруй төрлийн хичээлийг ашиглан дижитал анги удирдан, зохион байгуулахаас эхлэн алсын зайн хичээлийг боловсруулах ур чадварт суралцана
- Багш нар интерактив хичээл боловсруулахад суралцана

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✗ |
| АНГЛИ ХЭЛ | АНХАН ШАТ |

## БУСАД

| | |
|---|---|
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | ҮНЭГҮЙ |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ТИЙМ |

# БАГШ.МН

[www.bagsh.mn](http://www.bagsh.mn)




## ХУВИЛБАРУУД

АПП ✗

ВЭБ ✓

МЭД. ТЕХ ✓

БЛЭНДЭД АРГА ✗

ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ ✗

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Мэдээллийн технологийн болон бусад мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх хичээлийн сан
- Багш нар өөрсдөө хичээл боловсруулан нэмэлт орлого олох боломжтой

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✗ |
| АНГЛИ ХЭЛ | МОНГОЛ ХЭЛ |

## БУСАД

| | |
|---|---|
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | 1 хичээл 7к-50к |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ТИЙМ |

## APLUS.MN

https://aplus.mn/




## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МЭД. ТЕХ

БЛЭНДЭД АРГА

ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

Мэдээллийн технологийн болон бусад мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх хичээлийн сан

Дижитал иргэний боловсрол зэрэг үнэгүй хичээлийн сантай

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ

СУРАГЧ

АНГЛИ ХЭЛ

МОНГОЛ ХЭЛ

## БУСАД

| | |
|---|---|
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | 1 сар 29к |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ТИЙМ |

## MELEARN.MN

https://www.melearn.mn/




## ХУВИЛБАРУУД

✗ АПП

ВЭБ

✓ МЭД. ТЕХ

✗ БЛЭНДЭД АРГА

✗ ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Мэдээллийн технологийн болон бусад хувь хүний, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх хичээлийн сан
- Сонсдог сургалтуудтай

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✓ |
| СУРАГЧ | ✗ |
| АНГЛИ ХЭЛ | МОНГОЛ ХЭЛ |

## БУСАД

| | |
|---|---|
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | 3 сар 99к |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ТИЙМ |

# KAHOOT

https://kahoot.com/ Android & iOS




## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МЭД. ТЕХ

БЛЭНДЭД АРГА

ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Багш нар суралцагчдын даалгаврын үнэлгээг цахимаар хийх боломжтой
- Цахим, аппликэйшн хувилбарыг зэрэг удирдах, ашиглах боломжтой

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ

СУРАГЧ

АНГЛИ ХЭЛ АНХАН ШАТ

## БУСАД

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 20 сурагчтай багш 1 сард 10$

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ ТИЙМ

## BOUNCY BALLS

https://bouncyballs.org/




## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МЭД. ТЕХ

БЛЭНДЭД АРГА

ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

- хичээлийн явцад виртуал ангийн чимээ, шуугианд хяналт тавих боломжтой
- Цахим хичээлд оролцогч сурагчдын чимээ ихсэх тусам дэлгэц дээрх бөмбөлгүүдийн хөдөлгөөн ихэснэ

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ

СУРАГЧ

АНГЛИ ХЭЛ АНХАН ШАТ

## БУСАД

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ ҮНЭГҮЙ

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ ТИЙМ

## SOCRATIVE TEACHER

https://www.socrative.com/ Android & iOS







## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МЭД. ТЕХ

БЛЭНДЭД АРГА

ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

- Багш нар блэндэд арга зүйн чадвараа хөгжүүлэх, суралцагчдынхаа суралцахуйд дэмжлэг үзүүлэх чадварт суралцана
- Алсын зайн сургалт, Интерактив хичээл боловсруулахад суралцана

## ХЭРЭГЛЭГЧ

| | |
|---|---|
| БАГШ | ✔ |
| СУРАГЧ | ✖ |
| АНГЛИ ХЭЛ | АНХАН, ДУНД ШАТ |

## БУСАД

| | |
|---|---|
| ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ | ҮНЭГҮЙ |
| БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ | ТИЙМ |

## SLIDO

[https://www.sli.do/](https://www.sli.do/)  Android & iOS







## ХУВИЛБАРУУД

АПП

ВЭБ

МЭД. ТЕХ

БЛЭНДЭД АРГА

ИНТЕРАКТИВ ХИЧЭЭЛ

## АШИГЛАХ БОЛОМЖ

интерактив асуулт, асуулга бэлтгэн, цахим хичээлийн идэвх оролцоог нэмэгдүүлэх боломжтой

Алсын зайн сургалт, Интерактив хичээл боловсруулахад суралцана

## ХЭРЭГЛЭГЧ

БАГШ ✓

СУРАГЧ ✓

АНГЛИ ХЭЛ АНХАН, ДУНД ШАТ

## БУСАД

ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ ҮНЭГҮЙ

БҮРТГҮҮЛЭХ ЭСЭХ ТИЙМ

Хэрэгжүүлэгч: Боловсрол, шинжлэх ухааны яам
Санхүүжилт: Дэлхийн банк
Боловсролын чанарын шинэчлэл төслийн алба
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Сити тауэр 1201 тоот
Утас: 7000-2998
Имэйл: eqrpmon@gmail.com